**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**Аудитын нэр: "2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ" ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ**

САГ-2018-02-СА-ХөТАГ

*УИХ-ын төсвийн байнгын хорооны 2018 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитын тайлан.*




***2018 оны орлогын төлөвлөгөө 690.7 гаруй сая төгрөгөөр тасрах нөхцөл байдал үүсээд байна.***



***Хөвсгөл аймаг 2018 он***



## АГУУЛГА

***Тайланг бэлтгэсэн:***

*Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар*

*Санхүүгийн тайлангийн аудитын алба*

*Тэргүүлэх аудитор*
*О. Ганболд*
*Аудитын менежер*
*Ж.Отгончимэг*
*Ахлах аудитор*
*Б.Тэгшдэлгэр*

***2018 оны 10 сар***

*Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70384043 дугаарын утас, 70383793 дугаарын факсаар харилцана уу*

***ХАЯГ:*** *Мөрөн сум Аймгийн ЗДТГ-ын “А” корпус 3 давхар*
**Цахим хаяг:** *audit.gov.mn*

***Товчилсон үгийн тайлбар***

***Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй***

***Бүлэг 1. Төсөвт тодотгол хийсэн нь Төсвийн тухай хуулийн 34.2-т заасан нөхцөл байдалтай нийцэхгүй байна.***

***1.1. Засгийн газраас баталсан төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулсан байна.***

***1.2. Хөвсгөл аймгийн 2018 оны төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс орлогын 1,288.5 сая төгрөг, зарлагын 1,529.5 сая төгрөгийн зөрчил илэрч байна.***

***1.3. Хөвсгөл аймгийн 2018 оны төсвийн алдагдал, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийг бодитой тооцсон байна.***

***Бүлэг 2. 2018 оны орлогын төлөвлөгөө 690.7 сая төгрөгөөр тасрах нөхцөл байдал үүсээд байна.***

***2.1. 2018 оны орлогын төлөвлөгөө 690.7 сая төгрөгөөр тасрах нөхцөл байдал үүсээд байна.***

***2.2. 2018 оны орон нутгийн төсвийн орлогыг 160.0 гаруй сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байсан.***

***Бүлэг 3. Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулснаас 471.2 сая төгрөгийн өр үүсээд байна.***

***3.1. Зарим төсвийн шууд захирагч нар нь батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулаагүйгээс 471.2 сая төгрөгийн өр үүсээд байна.***

***3.2. Төсвийн хөрөнгөөр “Барих – шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн Шинэ-идэр сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгыг 2016 оны 12 дугаар сарын 25-нд ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.***

***3.3. Нийт хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 40,6 хувьтай байгаа ба үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл арга хэмжээ нь 32,7 хувь буюу хамгийн бага гүйцэтгэлтэй байна.***

***3.4. Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрөөр олгосон зээлийн эргэн төлөх үлдэгдлээс 157 иргэнтэй /таалал төгссөн/ холбоотой 136.0 сая төгрөгийг барагдуулах боломж алдагдсан байна.***

***Бүлэг 4. Сумын ТТЗ нар нь хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн биелэлтийг тооцож, тайлагнаж хэвшээгүй, түүнд тавих дотоод хяналт хангалтгүй байна.***

***4.1. Сумын ТТЗ нар хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн биелэлтийг тооцож, тайлагнаж хэвшээгүй***

***байна.***

***4.2. ТЕЗ-ийн хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн биелэлт 86,5 хувьтай байна.***

***4.3. Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна.***

***Дүгнэлт***

***Зөвлөмж***

***Хавсралт№-1***

***Хавсралт№-2***

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

| | |
|---|---|
| УИХ | Улсын Их Хурал |
| МУ | Монгол Улс |
| ЗГ | Засгийн газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| ИТХТ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ОНӨҮГ | Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар |
| СДОА | Сум дундын ойн анги |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХК | Хувьцаат компани |
| СТСХ | Санхүү төрийн сангийн хэлтэс |
| ОНХНС | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ОНХО | Орон нутгийн хөрөнгө оруулалт |
| БХНСАХ | Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ |
| ХБИ | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн |
| ОНӨҮГ | Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| ХБХ | Хөгжлийн бодлогын хэлтэс |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| БСШУСЯ | Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яам |
| СХС | Сум хөгжүүлэх сан |
| СДОА | Сум дундын ойн анги |
| ХөТАГ | Хөвсгөл төрийн аудитын газар |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| БГАҮХ | Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний хураамж |
| ХШҮДАХ | Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс |
| ХХААХҮС | Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн сайд |

### *Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, бүрэлдэхүүн*

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаалаар батлагдсан Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газрын 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

### Аудитын зорилт

Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцыг шалгаж, дүгнэлт гарган аймгийн ИТХ, Засаг дарга, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс болон бусад холбогдох байгууллага албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Аймгийн 2018 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх.
- 2018 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх.
- Аймгийн 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх.
- Аймгийн ТЕЗ-ын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх

### Аудитын хамарсан хүрээ

Хөвсгөл аймгийн ТЕЗ-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд, Алаг-эрдэнэ, Арбулаг, Галт, Жаргалант, Бүрэнтогтох, Цагаан-уул, Цагаан-үүр, Чандмань-өндөр, Шинэ-идэр, Түнэл, Улаан-уул, Рэнчинлхүмбэ, Мөрөн сумдын ТТЗ-дын 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.

### Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын Дээд байгууллагуудын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж ажилласан.

### Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

Хуулиуд:

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Монгол улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Өрийн удирдлагын тухай хууль
- Ирээдүйн өв сангийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль
- Бусад холбогдох хууль, тогтоомж, журам, заавруud
- Аймгийн ИТХ-ын 2017 оны 06 дугаар тогтоол
- Аймгийн ИТХ-ын 2018 оны 01 дүгээр тогтоол

### *Аудит хийсэн бүрэлдэхүүн*

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор О.Ганболд хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Ж.Отгончимэг хэрэгжүүлж, Санхүүгийн аудитын алба, ахлах аудитор Б.Тэгшдэлгэр төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн. Аудитыг гүйцэтгэх багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж багаар ажиллах боломжгүй болсон тул цаг хугацаа болон хүн хүчний хувьд нилээд хүндрэлтэй байсан болно.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох баримт, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

## Бүлэг 1

***Төсөвт тодотгол хийсэн нь Төсвийн тухай хуулийн 34.2-т заасан нөхцөл байдалтай нийцэхгүй байна.***

### *Үндсэн мэдээлэл:*

Сангийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ний 4-1/4116 тоот албан бичгээр “Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн хязгаар”-т багтаан 2018 оны төсвийн төслийг боловсруулах, Төсвийн тухай хуулинд заасан цаглабарын хүрээнд ирүүлэх, төсвийн төсөл бэлтгэхэд баримтлах зарчим, удирдамжийг ирүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 06 тоот хуралдааны тогтоолоор Аймгийн 2016 оны төсвийн гүйцэтгэл, 2018 оны төсвийг баталсан.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 2 дугаар сарын 07-ний өдрийн хуралдааны 01 тоот тогтоолоор давсан орлого, дансны үлдэгдлийг нэмж тодотгосон байна.

Аймгийн Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу яамдын сайд нартай үр дүнгийн гэрээ байгуулсан байна.

### *1.1. Засгийн газраас баталсан төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулсан байна.*

1.1.1. Сангийн яам 2017 оны 7 дугаар сарын 04-ний 4-1/4116 тоот албан бичгээр аймгийн Засаг даргад “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018-2020 оны төсвийн төслийг бэлтгэх удирдамж”-ийг ирүүлсэн байна.

1.1.2. Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн төвлөрүүлэн захирагч нарт орон нутгийн төсвийн төсөл боловсруулах удирдамжийг хүргүүлсэн байна.

1.1.3. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 *”төсвийн ерөнхийлөн захирагч дунд хугацааны төсвийн хүрээний мэдээлэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэх”* гэсэн заалтын дагуу аймгийн ТЕЗ-ийн 2018 оны төсвийн хязгаарын саналаа боловсруулж Сангийн яаманд хүргүүлээгүй байна.

1.1.4. Хөвсгөл аймгийн 2018 оны ТЕЗ-ийн төсвийн төсөл боловсруулж, хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлсэн байна. Хөвсгөл аймгийн төсвийн төсөл боловсруулахдаа Сангийн яамны баталсан төсвийн хязгаарт багтаан боловсруулсан байна.

1.1.5. Тухайн жилийн төсвийн төслийг боловсруулахдаа сумын ТТЗ буюу Засаг дарга нар харьяалагдах төсвийн шууд захирагч нарын төсвийн төслийг хууль, журмын хугацаанд хүлээн авч нэгтгэхгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1 *“төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд*

*захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх"* заалт, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 4.3.1[1], 4.3.2[2] дах заалтуудыг зөрчиж байна.

1.1.6. Аймгийн ИТХ-ын 2018 оны 2 дугаар сарын 07-ний өдрийн 01 тоот тогтоолоор давсан орлого дансны үлдэгдэл 2,428.4 сая төгрөгийг зарцуулах тодотгол хийсэн байна. Сангийн яамнаас 2018 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 4-1/3092 тоот албан бичгээр Төсвийн тухай хууль болон Засгийн газраас 2018 онд баримталж буй төсвийн бодлого чиглэлтэй нийцэхгүй байгаа тул төсвийн тодотголын саналыг Сангийн сайдын хувьд хүлээн авч шийдвэрлэх боломжгүй талаар уламжилсан байна. Гэвч Сангийн яам 2018 оны 8 дугаар сард төсвийн тодотголыг хүлээн зөвшөөрч зарцуулах эрхийг нээж өгсөн гэж байгаа боловч нотлох баримт байхгүй байна.

1.1.7. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.5.*"аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн батлагдсан төсвийг 12 дугаар сарын 31-ний дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх"* гэсэн заалтын дагуу аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ний 06 тоот тогтоолоор батлагдсан төсвийг аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 26-ны 1/3007 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

### *1.2. Хөвсгөл аймгийн 2018 оны төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс орлогын 1,288.5 сая төгрөг, зарлагын 1,529.5 сая төгрөгийн зөрчил илэрч байна.*

1.2.1. Аймгийн 2018 оны орон нутгийн төсвийг боловсруулахад дараах зарчим баримталсан байна. Үүнд:

- МУ-ын 2018 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан орон нутгийн төсөв боловсруулахад баримталсан зарчим, бодлогын арга хэмжээ
- Сумын орлогыг тооцохдоо эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлоготой уялдуулан УИХ-аас ирүүлсэн орон нутгийн төсвийн суурь орлогын хязгаарт үндэслэн төлөвлөх
- Аймгийн орлого бүрдүүлэх боломжийг судлан сумын санал, мэргэжлийн байгууллага, сүүлийн 5 жилийн орлого бүрдүүлэлтийн байдалд үндэслэн орлогыг зохистой түвшинд төлөвлөх
- Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулахгүй байх
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2018 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангах эх үүсвэрийг бүрдүүлэх

1.2.2. Орон нутаг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 2018 оны орлогын эх үүсвэрийг 94,790.3 сая төгрөг байхаар төлөвлөсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

[1] Орон нутгийн төсөвт байгууллага болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зориулултын шилжүүлгийн гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсөвт байгууллагын төсвийн захирагч сум, дүүргийн Засаг даргад суурь төсвийн саналыг жил бүрийн 7 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.

[2] Сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсөвт байгууллага болон тусгай зориулалтын гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсвийн байгууллагын суурь төсвийн саналыг нэгтгэн аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор хүргүүлнэ.

*Хүснэгт №-1* */сая,төг/*

| № | Санхүүжилтийн эх үүсвэр | 2017 оны тодотгосон төсөв | 2018 оны төсвийн төсөл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | Санхүүгийн дэмжлэг | 17,963.9 | 20,846.5 | 2,882.6 |
| 2 | ОНХС-ын орлогын шилжүүлэг | 2,189.4 | 5,455.4 | 3,266.0 |
| **3** | Тусгай зориулалтын шилжүүлгээс | 54,615.8 | 57,389.3 | 2,773.5 |
| **4** | Аймгийн орлого | 6,639.3 | 6,865.5 | 226.2 |
| **5** | Сумын орлого | 4,094.7 | 4,165.2 | 70.5 |
| **6** | Төсвийн байгууллагын өөрийн орлого | 471.6 | 75.5 | 396.1 |
| **7** | Давсан орлого дансны үлдэгдэл | 3,450.3 | 14.6 | 3,435.7 |
| **8** | **Нийт дүн** | **89,425.0** | **94,790.3** | **5,365.3** |

***Хүснэгтээс харахад:*** 2018 онд орлогын эх үүсвэрийг өмнөх оноос 5,4 тэрбум төгрөг буюу 5,9 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

1.2.3. Орон нутаг, тусгай шилжүүлгийн байгууллагуудын 2018 оны орлогын эх үүсвэрийн 20,846.5 сая төгрөг буюу 22 хувийг санхүүгийн дэмжлэг, 5,455.4 сая төгрөг буюу 5,8 хувийг орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг, 57,389.3 сая төгрөг буюу 60,2 хувийг тусгай шилжүүлэг, 6,865.5 сая төгрөг буюу 7,2 хувийг аймгийн орлого, 4,165.2 сая төгрөг буюу 4,4 хувийг сумын орлого, 68.4 сая төгрөг буюу 0,1 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого давсан орлого, дансны үлдэгдэл тус тус эзэлж байна.

1.2.4. Орлогын өөрчлөлтөд дараах хүчин зүйл нөлөөлсөн байна. Үүнд:

- *Хүн амын орлогын албан татварын шинэчлэлээр 2017 оны 5 сараас эхлэн иргэдийн банкинд хадгалуулсан хадгаламжийн хүүгийн орлогоос татвар авах болсон.*
- *2018 оны хадгаламжийн хүүгийн орлогын албан татвар сумдын орон нутгийн орлогын төлөвлөгөөнд тусгагдсантай холбоотой Мөрөн суманд санхүүгийн дэмжлэг төлөвлөөгүй байна.*

1.2.5. 2018 онд ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг 4,166.3 сая төгрөг, Тогтвортой амьжиргаа төслөөс сумдын ОНХС-д олгох дэмжлэг 1,243.9 сая төгрөг, нэр бүхий 15 суманд олгох урамшуулалд 45.1 сая төгрөгийг баталж иргүүлсэн байна. Мөн ОНХС-д төвлөрүүлэх нийт орлого суурь орлогын зөрүү 100.0 сая төгрөгийн эх үүсвэрийг нэмж төлөвлөсөн байна.

1.2.6. ОНХС-ийн хөрөнгийг Төсвийн тухай хуулийн 59.2 дах заалт, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу бүх сумдад хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамааруулан тооцож төлөвлөсөн байна.

1.2.7. Орон нутгийн төсвийн суурь орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 174.9 сая төгрөгөөр аймгийн ИТХ өсгөж баталсан байна.

*ХүснэгтNo-2* */ сая төг/*

| № | Үзүүлэлт | Сангийн яамны хянасан дүн | 2018 он | |
|---|---|---|---|---|
| | | | Анх батлагдсан /2017.12.04-06/ | Тодотгол-1 /2018.02.07-01/ |
| А | Б | 1 | 2 | 3 |
| 1 | Орон нутгийн төсвийн суурь орлого | 10,949.8 | 11,063.3 | 11,124.7 |

1.2.8. 2018 оны орон нутгийн орлогыг 11,084.5 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

*ХүснэгтNo-3* */сая төг/*

| № | Орлогын нэр төрөл | Дүн | хувь |
|---|---|---|---|
| **1** | Хувь хүний орлогын албан татвар | 8,107.5 | 73,1 |
| **2** | Буцаан олголт | -1,300.0 | -11,7 |
| **3** | Өмчийн татвар | 958,0 | 8,6 |
| **4** | Бусад татвар | 951.6 | 8,6 |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 1,772.9 | 16,0 |
| 7 | Татварын бус орлого | 559.5 | 5,0 |
| 8 | Хөрөнгө борлуулсны орлого | 35.0 | 0,3 |
| 9 | Дүн | 11,084.5 | 100 |

*График 1.*




2018 оны төсвийн орон нутгийн орлогыг 2016 оны гүйцэтгэл, 2017 оны төлөвлөгөөтэй харьцуулбал: 2016 оны гүйцэтгэлээс 831.2 сая төгрөг буюу 8,1 хувиар, 2017 оны төлөвлөгөөнөөс 316.7 сая төгрөг буюу 2,9 хувиар, 2017 оны сангийн яаманд хянуулсан дүнгээс 290.1 сая төгрөг буюу 2,5 хувиар нэмэгдүүлж тооцсон байна.

1.2.9. *График 2.*




Орон нутгийн орлогын 6,895.8 сая төгрөг буюу 62,2 хувийг аймгийн орлого, 4,188.7 сая төгрөг буюу 37,8 хувийг сумын орлого эзэлж байна.

1.2.10. Аймгийн орлогын 6,895.8 сая төгрөгийг 2016 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 25.2 сая төгрөг буюу 0,4 хувиар буурсан, 2017 оны төлөвлөгөөнөөс 330.9 сая төгрөг буюу 5 хувиар, 2018 оны Сангийн яаманд хянуулсан дүнгээс 108.1 сая төгрөг буюу 1,6 хувиар тус тус нэмэгдүүлсэн байна.

1.2.11. Сумын орлого 4,188.7 сая төгрөгийг 2016 оны гүйцэтгэлээс 856.4 сая төгрөг буюу 25,7 хувиар нэмэгдэж, 2017 оны төлөвлөгөөнөөс 14.2 сая төгрөг буюу 0,3 хувиар буурч, 2018 оны Сангийн яаманд хянуулсан дүнгээс 182.0 сая төгрөг буюу 4,5 хувиар нэмэгдүүлж тооцсон байна.

*График 3.*




1.2.12. Аймгийн орон нутгийн байгууллагуудын 2018 оны төсвийн зарлага УИХ-аас 31,640.8 сая төгрөгөөр батлагдаж ирсэн нь 2017 оны төсөвтэй харьцуулахад 19,8 хувь буюу 5,228.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн өөрчлөлтөд хөрөнгө оруулалтын зардал 4,513.0 сая

төгрөг, төрийн албан хаагчдын ажлын үр дүнг харгалзан олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын 265.8 сая төгрөг голлох хувийг эзэлж байна.

1.2.12. 2018 оны төсөвт сумдын ЗДТГ-ын цалинг 216.6 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 95.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Мөн орлогын төлөвлөгөө болон биелэлтийн өсөлтөөс хамаарч БХНСАХ-ний зардал 290.9 сая төгрөгөөр, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг 35.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж баталсан бол халамж үйлчилгээний зардлыг 225.9 сая төгрөгөөр бууруулж, халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, ахмад настан болон ХБИ-д үзүүлэх хөнгөлөлтүүд болон хүнс тэжээлийн нэмэгдэл зэргийг 1,236.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

1.2.13. *График 4.*




Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 2018 онд 57,389.3 сая төгрөгөөр батлагдаж ирсэн нь 2017 онтой харьцуулахад 4,9 хувь буюу 2,699.9 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

1.2.14. Аудитаар төсвийн төлөвлөлттэй холбоотой дараах зөрчил илэрч байна. Үүнд:

- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-т заасан хувь хэмжээгээр тооцож төлөвлөөгүйгээс 595.6 сая төгрөгийг дутуу тооцсон байна.***Тухайлбал:***

*Хүснэгт№-4* *\/мян төг/*

| № | Үзүүлэлт | 2018 онд төлөвлөсөн | хувь | БХНСЗ-д хуваарилах дүн | БХНСЗ-д хуваарилсан дүн | зөрүү |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого | 25,175.0 | 15% | 3,776.25 | 3,700.0 | 76.25 |
| 2 | Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого | 102,800.0 | 50% | 51,400.0 | 47,500.0 | 3,900.0 |
| 3 | Газрын нөөцийн төлбөрийн орлого | 259,085.5 | 15% | 38,862.83 | 31,500.0 | 7,362.8 |
| 4 | Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого | 1,608,512.0 | 85% | 1,367,235.2 | 789,500.0 | 577,735.2 |
| 5 | Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого | 46,800.0 | 35% | 16,380.00 | 9,900.0 | 6,480.0 |
| ***6*** | ***Нийт*** | ***2,042,372.5*** | | ***1,477,654.28*** | ***882,100.0*** | ***595,554.3*** |

- Орон нутгийн байгууллагуудын халаалтын зардлын өртөг тооцохгүйгээр суурь үнийг 1738 төгрөг буюу өмнөх суурь үнээс 308 төгрөг нэмэгдүүлэн тооцож нийт 689.9 мкуб талбайг 1,487.5 сая төгрөгөөр халаахаар тооцсон байна.
- Ойн нөөц ашигласны төлбөр /самрын орлого/-ийг Сангийн яам хянахдаа орон нутгийн саналыг харгалзахгүйгээр 690.7 сая төгрөгийг нэмсэн байна.
- Шинэ-идэр суманд ургамлын нөөц ашигласны төлбөрт *2.2* сая төгрөг төлөвлөсөн байна.

- Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн цалингийн зардлыг 25.0 сая төгрөгөөр, Улаан-уул сумын ерөнхий боловсролын сургуулийн цалингийн зардлыг 17.0 сая төгрөгөөр тус тус дутуу төлөвлөж тусгасан байна.

Дээрх алдаа зөрчлөөс харахад аймгийн төсөвийг төлөвлөхдөө холбогдох хууль, журам, орон нутгийн төсвийг төлөвлөх аргачлал шалгуур үзүүлэлт, тооцоо судалгааг бодит байдалд нийцүүлээгүй, тухайн оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### *1.3. Хөвсгөл аймгийн 2018 оны төсвийн алдагдал, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийг бодитой тооцсон байна.*

1.3.1. Хөвсгөл аймгийн 2018 оны суурь орлогыг 9,552.0 сая төгрөг, суурь зардлыг 25,861.7 сая төгрөгөөр тооцон 16,309.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор баталсан байна.

1.3.2. Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 06 тоот тогтоолоор улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 20,846.5 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд хөрөнгө оруулалтын санхүүжилт 4,536.9 сая төгрөгийг тооцож оруулсан байна.

1.3.3. Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 06 тоот тогтоолоор 4,716.8 сая төгрөгөөр баталсан байна.

1.3.4. 2018 онд Мөрөн сум анх удаагаа аймгаас санхүүгийн дэмжлэг авахгүйгээр өөрийгөө санхүүжүүлж байна.

***2018 оны аймгийн ОНО-ын төлөвлөгөө 690.7 сая төгрөгөөр тасрах нөхцөл байдал үүсээд байна.***

# Бүлэг 2

### *2.1. 2018 оны орлогын төлөвлөгөө 690.7 сая төгрөгөөр тасрах нөхцөл байдал үүсээд байна.*

2.1.1. 2018 онд нийт орлого ба тусламжийг 97,679.7 сая төгрөгөөр баталж, тодотголоор 3,575.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 101,255.0 сая төгрөг болгосон байна. 2018 оны 3 дугаар улирлын байдлаарх төсвийн гүйцэтгэлийн тайлангаас харахад зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 98,3 хувийн гүйцэтгэлтэй ба төлөвлөснөөс 1,321.7 сая төгрөгийн эх үүсвэрийг дутуу бүрдүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

*Хүснэгт№-5* *_/сая.төг/_*

| № | Үзүүлэлт | Төлөв | Гүйц | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 40,968.6 | 40,968.6 | 0,0 | 100,0 |
| 2 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас | 4,123,9 | 4.123.9 | 0.0 | 100,0 |
| 3 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 30,387.0 | 30,135.7 | -251.3 | 99,2 |
| 4 | Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 310.2 | 476.0 | 4.6 | 116,6 |
| 5 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | 1,441.8 | 1,068.4 | -373,4 | 74,1 |
| 6 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 862.8 | 0 | -862.8 | 0.0 |
| 5 | Дүн | 78,094.3 | 76,772.6 | -1,321.7 | 98,3 |

2.1.2. Орон нутгийн орлого 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 105,1 хувийн гүйцэтгэлтэй байгаа ба 386.2 сая төгрөгөөр давж биелсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

*Хүснэгт№-6* */сая төг/*

| № | Үзүүлэлт | Төлөв | Гүйц | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Татварын орлого | 7,227.7 | 7,483.4 | 255.5 | 103,5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Татварын бус орлого | 414.4 | 545.1 | 130.7 | 130,8 |
| 3 | Нийт | 7,642.1 | 8,028.5 | 386.2 | 105,1 |

2.1.3. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг Алаг-эрдэнэ сум 6,7 хувь буюу 4,4 сая төгрөг, Галт сум 55,3 хувь буюу 97.4 сая төгрөг, Жаргалант сум 36,3 хувь буюу 60.4 сая төгрөг, Төмөрбулаг сум 1 хувь буюу 0.7 сая төгрөг, Чандмань-өндөр сум 39,3 хувь буюу 43.5 сая төгрөг, Эрдэнэбулган сум 35,6 хувь буюу 44.2 сая төгрөг нийт 250.6 сая төгрөгөөр тус тус тасалсан байна. Дээрх сумдын ТТЗ-д Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т заасан хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

2.1.4. Тасарсан орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт№-7* */сая төг/*

| **Үзүүлэлт** | **Төлөв** | **Гүйц** | **+/-** | **Хувь** | **Тайлбар, шалтгаан** |
|---|---|---|---|---|---|
| Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөрийн хөлс | 4,859.3 | 4,656.0 | -203.2 | 95,8 | ЗГ-ын 2018 оны 264 дүгээр тогтоолоор нэмэгдсэн цалингийн нэмэгдэл 2018 оны 9 сарын цалингийн зардлын төлөвлөлтөд тусгагдаагүйгээс ХХОАТ-ын өр үүссэн байна. |
| Бууны албан татвар | 50.3 | 48.8 | -1.5 | 97,0 | Цаашид гүйцэтгэлийг бүрэн хангах боломжтой байна. |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 28.8 | 13.0 | -15.8 | 45,0 | Үндэслэлтэй төлөвлөөгүйгээс орлого тасарч байна. |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 251.2 | 188.6 | -62.7 | 75,1 | Хог хаягдлын хураамжийн төлбөрийг дутуу төвлөрүүлсэн тул орлого тасарсан байна. |
| Газрын төлбөр | 146.1 | 127.6 | -18.5 | 87,3 | Газрын төлбөрийг төлөвлөсөн хэмжээгээр төвлөрүүлж чадаагүй байна. |
| Ойн нөөц ашигласны төлбөр | 970.7 | 670.1 | -300.6 | 69,0 | Энэ жил Галт,Жаргалант, Тариалан, Цагаан-Үүр, Чандмань-өндөр, Эрдэнэбулган сумдад төлөвлөгдсөн үйлдвэрлэлийн зориулалттай самрын орлого тасарсан. Энэ онд самар ургаагүй байна. Цаашид биелэгдэх боломжгүй нөхцөл байдал үүссэн байна. |
| Хувьцааны ногдол ашиг | 18.5 | 0 | -18.5 | 0 | “Могойн гол” ХК-аас төвлөрүүлэх хувьцааны ногдол ашгийн төвлөрүүлээгүй байна. |

Цаашид 2018 оны жилийн эцсээр орон нутгийн орлогын гүйцэтгэлийг хангаж ажиллахгүй байх нөхцөл байдал үүсээд байна. Үүнд дараах хүчин зүйл нөлөөлж байна.

- *2018 оны орлогын төлөвлөгөөнд ойн нөөц ашигласны төлбөр нийт* 690.7 *сая төгрөгийн орлого биелэгдэх боломжгүй болсон байна.* ***/Энэ жил самар ургаагүй байна./***

2.1.5. Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж байгаа дараах улсын төсвийн байгууллагуудад 2018 онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг төлөвлөсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

*Хүснэгт№-8* */мян төг/*

| **№** | **Байгууллагын нэр** | **Жилийн төлөв** | **Төлөв** | **Гүйц** | **Зөрүү** |
|---|---|---|---|---|---|
| 1 | Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар | 56,500.0 | 20,700.0 | 34,170.0 | 13,470.0 |
| 2 | Улсын бүртгэлийн хэлтэс | 250,000.0 | 125,000.0 | 141,712.4 | 16,712.4 |
| 3 | Стандарт, хэмжил зүйн хэлтэс | 15,000.0 | 7,000.0 | 8,020.4 | 1,020.4 |
| 4 | Нийт орлого | 321,500.0 | 152,700.0 | 183,902.8 | 31,202.8 |

2018 оны эхний хагас жилийн байдлаар Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж байгаа улсын төсөвт байгууллагууд нь 2018 оны эхний хагас жилийн байдлаар улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлж, төлөвлөсөн хэмжээнээс 31,202.8 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

## 2.2. 2018 оны орон нутгийн төсвийн орлогыг 160.0 гаруй сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

2.2.1. 2018 оны төсвийн төсөлд Хөвсгөл аймаг дах Төрийн аудитын газраас ***160.0*** гаруй сая төгрөгийн орлогыг нэмэгдүүлж төлөвлөх боломж байгаа талаар дараах санал хүргүүлж байсан болно. Үүнд:

- Аймаг, сумдад үйл ажиллагаа явуулж байгаа ОНӨҮГ-ын ашгаас 100,0 орчим сая төгрөгөөр, аймаг, сумын орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх боломж байна. ***Үндэслэл:*** Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон ашгийг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.1, 23.9.1 заалтаар орон нутгийн төсөвт төвлөрүүлэх.
- Цагдаагийн байгууллага галт зэвсгийн бүртгэл, хөдөлгөөний мэдээг Татварын албанд ирүүлбэл бууны татварын орлогыг бодитой төлөвлөх, ингэснээр орлогыг 10 орчим сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна. ***Үндэслэл:*** Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 заалтын дагуу албан татвар ногдуулах
- Ус ашиглагчтай гэрээ байгуулах, гэрчилгээ олгох, мал эмнэлэг ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээ олгох зэрэгт Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.7[3], 35.1.21[4] дагуу орлого тооцож төлөвлөх талаар сумын ИТХ болон ТТЗ нарыг удирдлагаар хангаж ажиллавал 50.0 орчим сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэх боломж байна. ***Үндэслэл:*** Аймгийн ИТХТ-ийн 2011 оны 98 дугаар тогтоолоор улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээгээр хураамж тооцон төлөвлөөгүй байна. Эдгээр санал нь биелэгдэх боломж байгаа нь аудитаар харагдаж байна.

2.2.2. Орон нутгийн өмчит компаниудыг 2018 онд 502.7 сая төгрөг, орон нутгийн өмчийн оролцоотой “Могойн гол” ХК-ийг 187.0 сая төгрөгийн ашигтай ажиллах, харин “Дэлгэр-мөрөн” СДОА-ийг 14.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллах төлөвлөгөө баталсан байна.

2.2.3. 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар компаинудын ашиг, алдагдал нь дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт№-9* *Ісая төг/*

| № | Аж ахуйн нэгжийн нэр | Ашиг алдагдал |
|---|---|---|
| 1 | “Могойн гол” ХК | 262.7 |
| 2 | Хөвсгөлийн эмийн эргэлтийн сан ОНӨХК | 24.3 |
| 3 | Шинэ мөрөн худалдааны төв ХК | 97.4 |
| 4 | Хөвсгөл эрчим хүч ХХК | 91.9 |
| 5 | Хөвсгөл ус суваг ХХК | 23.6 |
| 6 | Хоймор нутгийн чулуу ХХК | -27.8 |
| 7 | Уран дөш ОНӨҮГ | 17.6 |
| 8 | Нийтийн ахуй үйлчилгээний төв ХХК | 43.7 |
| 9 | Тосон илч ХХК | 11.4 |
| 10 | Түнэл Илч ХХК | 0.4 |
| 11 | Галт дулаан ХХК | 42.8 |
| 12 | Тэсийн Илч ХХК | 3.0 |
| 13 | Шинэ-Идэр дулаан эрдэнэт ХХК | -39.3 |
| 14 | Их-уул дулаан ХХК | 41.1 |
| 15 | Дэлгэр-мөрөн СДОА | -5.6 |
| 16 | Баяншишгэд СДОА | 1.8 |
| 17 | Эрчимт Идэр СДОА | -2.4 |
| 18 | Нарс шинсэн төгөл СДОА | -1.6 |

***Хүснэгтээс харахад:*** Нийт 18 аж ахуйн нэгжүүдээс 5 аж ахуйн нэгж 2018 оны эхний хагас жилийн байдлаар алдагдалтай ажилласан байна. Тухайн оны жилийн эцсээр дээрх аж ахуйн нэгжүүдийн ашиг алдагдлыг бодитой тооцож, орон нутгийн орлогыг тодорхой хувиар нэмэгдүүлэх боломж байгаа нь харагдаж байна.

*[3] 35.1.7.ус ашиглагчтай гэрээ байгуулж, 100 шоо метрээс бага ус ашиглуулах гэрчилгээ олгоход гэрээний жил тутамд 32 000-80 000 төгрөг, гэрээг сунгахад 20 000-50 000 төгрөг;*

*[4] 35.1.21.мал, түүний үржлийн чанар, ашиг шим, эрүүл мэнд болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг, шинжилгээ хийж гарал үүсэл, чанарыг тодорхойлон гэрчилгээ олгоход 2000-5000 төгрөг*

**Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулснаас 471.2 сая төгрөгийн өр үүсээд байна.**

# Бүлэг 3

## 3.1. Зарим төсвийн шууд захирагч нар нь батлагдсан төсөв, орон тооны хүрээнд үйл ажиллагаа явуулахгүй байгаагаас 471.2 сая төгрөгийн өр үүсээд байна.

3.1.1. Аймгийн ТЕЗ-ийн 2018 оны батлагдсан төсөв 101,255.0 сая төгрөг, 3 дугаар улирлын байдлаар 65,868.6 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлтэй байгаа бөгөөд хүлээгдэж байгаа гүйцэтгэл 35,386.4 сая төгрөг байна.

3.1.2. Төсвийн гүйцэтгэлээр 80 хувиас доош үзүүлэлттэй гарсан зардлыг бүлгийн дүнгээр авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд: Эд хогшил худалдан авах зардлын гүйцэтгэл 76,4 хувь, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж 68,2 хөрөнгийн зардал 71,6 хувь, эргэж төлөгдөх зээлийн гүйцэтгэл 58,8 хувьтай байгаа нь төсвийн гүйцэтгэлд нөлөөлсөн байна.

3.1.3. Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг тайлбарласан тайланг улирал бүр сумдын төсвийн төвлөрүүлэн захирагч нараас гаргуулан авч нэгтгэж байна. 2018 оны 3 дугаар улирлын байдлаар зардлуудыг бүлгийн дүнгээр хэтрэлт, хэмнэлт, шалтгааныг авч үзлээ. **/Хавсралт№-01-ээс үзнэ үү./**

3.1.4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 7,409.2 сая төгрөгийн авлагатай, 6,503.5 сая төгрөгийн өр төлбөртэй тайлагнасан байна. 2017 оны жилийн эцсийн үлдэгдэлтэй харьцуулахад авлага 8,4 хувиар, өр төлбөр 20,7 хувиар өссөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.(төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх) гэсэн заалт, ЗГ-ийн 2017 оны 337 дугаар тогтоолоор батлагдсан "2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээ"-ний 1.1 дэх заалтуудыг тус тус зөрчиж байна.

3.1.5. Төсвийн тодотголыг дараах зүйлд зарцуулахаар баталсан байна. Үүнийг графикаар харуулбал дараах байдалтай байна.




2018 онд төсөвт хийсэн тодотголын 39 хувь буюу 958.2 сая төгрөгийг ОНХО-д, 24 хувь буюу 589.7 сая төгрөгийг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээнд, 23 хувь буюу 548.2 сая төгрөгийг төсвийн урсгал зардалд, 11 хувь буюу 267.6 сая төгрөгийг БХНСАХ-ний зардалд, 3 хувь буюу 64.7 сая төгрөгийг замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд зарцуулахаар баталсан байна.

3.1.6. Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 (*Төсвийн ерөнхийлөн захирагч хоорондын төсвийн зохицуулалтыг зөвхөн тухайн жилийн төсөвт тодотгол хийж шийдвэрлэнэ*), Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ыг үндэслэн 2018 оны эхний хагас жилд аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/314 тоот тушаалаар дараах зохицуулалтыг хийсэн байна. Үүнд:

Төсөвт хийсэн зохицуулалтыг хүснэгтээр харуулбал:

*ХүснэгтNº-10* */мян.төг/*

| № | Зардлын зүйл /бүлэг/ | Орон нутгийн байгууллага | ЭМБ | ЕБС | СӨБ | Соёл |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 6,000.0 | 0 | 0 | 18,608.5 | 830.0 |
| 2 | Ажил олгогчоос төлөх НДШ | -432.0 | 0 | 250.0 | 2,377.0 | 99.6 |
| 3 | Тогтмол зардал | -19,600.0 | -8,800.0 | -5,321.0 | -7,144.0 | -1,282.0 |
| 4 | Хангамж БМ зардал | 2,390.0 | -1,200.0 | 4,315.2 | 1,617.7 | 1,142.0 |
| | Нормативт зардал | | 0 | -7,464.2 | -30,971.2 | |
| 5 | Эд хогшил, урсгал засвар | 5,992.4 | 9,790.0 | 12,125.7 | 14,730.0 | -189.6 |
| 6 | Томилолт зочны зардал | 0 | 0 | -500.0 | -376.5 | 400.0 |
| 7 | БГАҮХ | -1,861.6 | 210.0 | -1,011.0 | 1,729.4 | 0 |
| 8 | Бараа үйлчилгээний бусад зардал | 711.2 | 0 | -2,839.7 | -1,046.0 | 1000.0 |
| 9 | Бусад урсгал шилжүүлэг | 6,800.0 | 0 | 1,200.0 | 475.0 | 0 |
| 10 | Үдийн цай | 0 | 0 | -755.0 | 0 | 0 |

Төсөвт зохицуулалт хийсэн байдлаас харахад цалин болон нэмэгдэл урамшууллыг 25,438.5 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварыг 42,638.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, тогтмол зардлыг 42,147.0 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 38,435.4 мянган төгрөгөөр тус тус бууруулсан зохицуулалт хийсэн байна.

Энэ нь төсвийн зарлагыг боловсруулж батлуулахдаа цалин, тогтмол зардал, нормативт зардлын тооцооллыг бодитой төлөвлөөгүйг харуулж байна.

3.1.7. Төсөвт байгууллагуудын халаалтын зардалд өр төлбөр үүссэн ба өр төлбөрийг хүснэгтээр харуулбал:

*ХүснэгтNº-11* */сая төг/*

| № | Сумдын нэр | Өр төлбөр |
|---|---|---|
| 1 | Галт | 27.6 |
| 2 | Жаргалант | 9.7 |
| 3 | Рашаант | 47.2 |
| 4 | Төмөрбулаг | 137.7 |
| 5 | Бүрэнтогтох | 249.0 |
| ***6*** | ***Нийт*** | ***471.2*** |

Дээрх сумдад дулааны нэг метр куб халаалтын үнийг харилцан адилгүй тооцож гэрээ байгуулсан байна. ***Тухайлбал:*** Галт сум -1716 төгрөг, Жаргалант сум -1738 төгрөг, Төмөрбулаг сум -1738 төгрөг, Рашаант сум -1738 төгрөг, Бүрэнтогтох сум -1716 төгрөгөөр тус тус гэрээ байгуулсан байна. 2018 оны төсөвт халаалтын зардлыг тооцохдоо аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2009 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 01 тоот тогтоолоор баталсан үнэ тарифыг үндэслэл болгосон байна. Гэтэл дээрх сумдын төсөвт байгууллагууд халаалтын зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлэн “Гэрээ” байгуулж, эхний 9 сарын байдлаар 471.2 сая төгрөгийн өр үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2[5] заалт, ЗГ-ын 2017 оны 337 дугаар тогтоолын 7.3[6]-т гэсэн заалтыг тус тус зөрчиж байна.

**Аудитаар:** Цаашид хүчин төгөлдөр байгаа үнэ тарифийг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах албан шаардлагыг төсвийн шууд захирагч нарт хүргүүлж байна.

3.1.8. Аймаг дах Төрийн аудитын газраас 2018 оны төсвийн төсөлд санал хүргүүлэхдээ орон тооны талаар тодорхой саналуудыг өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэмжээнд 2018 оны эхний хагас жилийн байдлаар 9 орон тоо хэтрүүлэн ажиллаж байна. ***Үүнд:***

---

5 *батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;*

6 *“орон нутгийн дулааны үнэ тарифийг нэмэгдүүлэхгүй байх, төвлөрсөн халаалтад холбох, сумдын уурын зуухыг аймгийн төвийн уурын зуухтай нэгтгэн зохион байгуулахдаа төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байх, сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудын түлш халаалтын зардлыг өр, авлага үүсгэхгүйгээр батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлэх”*

*ХүснэгтNo-12* */мян төг/*

| Сум | Байгууллагын нэр | төлөв | гүйцэт | зөрүү | Цалин | НДШ | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Аймаг | Санхүүгийн хяналт аудитын алба | 6 | 8 | 2 | 14,090.4 | 1,690.8 | 15,781.2 |
| Аймаг | Аймгийн ИТХ | 9 | 10 | 1 | 3,639.9 | 436.8 | 4,076.7 |
| Шинэ-идэр | Хүүхдийн цэцэрлэг | 18 | 19 | 1 | 5303.3 | 636.4 | 5,939.7 |
| Цагааннуур | хүн эмнэлэг | 17 | 18 | 1 | 4,140.6 | 496.9 | 4,637.5 |
| Хатгал | Хүүхдийн цэцэрлэг | 26 | 27 | 1 | 3,362.4 | 403.5 | 3,765.9 |
| Мөрөн | 10-р цэцэрлэг | 27 | 28 | 1 | 3,362.2 | 403.5 | 3,765.7 |
| Мөрөн | 2-р сургууль | 98 | 100 | 2 | 12,968.8 | 1,556.3 | 14,525.1 |
| ***Нийт*** | | ***201*** | ***210*** | ***9*** | ***46,867.8*** | ***5,624.1*** | ***52,491.9*** |

Орон тоог хэтрүүлэн ажилласантай холбоотой цалин, НДШ-д 52,491.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ байдлаас шалтгаалан зарим байгууллагын төсөвт хүндрэл учирч байгаа нь харагдаж байна. ***Тухайлбал:*** Санхүүгийн хяналт аудитын алба нь цаашид цалингаа тавьж чадахгүй байдалд хүрсэн ба цалин НДШ-тэй холбоотой 27.9 сая төгрөгийн өр үүсэх нөхцөл байдал бий болсон байна.

3.1.9. Аймгийн ЗДТГ-ын бүтцийг шинэчлэн тогтоох тухай ЗГ-ын 2016 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 09 дүгээр тогтоолын 1-д аймгийн Засаг даргын орлогчийг 1 байхаар заасан байтал тус аймагт 2 орон тоогоор ажиллаж, цалин, НДШ-д 33.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

*ХүснэгтNo-13* */мян төг/*

| № | Онууд | Цалин | Ажилласан сар | цалин | НДШ | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | 2016 | 1,129.7 | 6 | 6,778.2 | 746.6 | 7,524.8 |
| **2** | 2017 | 1,129.7 | 12 | 13,556.4 | 1,491.2 | 15,047.6 |
| **3** | 2018 | 1,129.7 | 9 | 10,167.3 | 1,220.1 | 11,387,4 |
| **4** | ***Нийт*** | ***3,389.1*** | ***27*** | ***30,501.9*** | ***3,457.9*** | ***33,959.8*** |

Дээрх орон тоо, төсөвтэй холбоотой гарч байгаа зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 заалт, УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын 6[7] дах заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүйг харуулж байна.

3.1.10. ***Нэмэлт санхүүжилтийн талаар:*** Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу 2018 оны 3 дугаар улирлын байдлаар нэмэлт санхүүжилтын дансаар 1,092.8 сая төгрөгийн орлого хүлээн авч 856.9 сая төгрөгийг зарцуулж, 235.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

***3.2. Төсвийн хөрөнгөөр “Барих – шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн Шинэ-идэр сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгыг 2016 оны 12 дугаар сарын 25-нд ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.***

3.2.1. 2018 оны Төсвийн тухай хуулийн 3 дугаар хавсралтаар батлагдсан Төсвийн хөрөнгөөр 2018 онд “Барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн жагсаалтад 2,359.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Хөвсгөл аймгийн Шинэ-идэр сумын хүүхдийн

[7] *2017-2019 онд өндөр насны тэтгэвэрт гарах 2 төрийн албан хаагч тутамд 1 албан хаагчийг нөхөн томилох, энэ хугацаанд бусад салбарт төрийн албанаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн албан хаагчийн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байж, ажил, үүргийн хуваарийг шинэчлэн оновчтой тогтоох замаар ачааллыг нягтруулах, сул орон тоог зайлшгүй нөхөх шаардлагатай гэж үзвэл төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад дахин зохион байгуулалт хийх зарчмаар шийдвэрлэх*

цэцэрлэгийн барилгыг оруулсан ба 2018 онд 670.0 сая төгрөгийг нь санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Дээрх барилгыг “Барих шилжүүлэх” концессын төрлөөр “Хөвсгөл Геологи” ХХК нь 2016 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 2016 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулж, 2016 оны 12 дугаар сарын 25-нд хүлээлгэн өгч, 2017 оны 01 дүгээр сарын 01-нд ашиглаж эхэлсэн байна. Шинээр баригдсан хүүхдийн цэцэрлэг нь бүрэн хүчин чадлаараа ажиллаж 147 хүүхэд стандартын шаардлага хангасан орчинд хүмүүжиж байгаа талаар сумын удирдлага ярьж байна.

3.2.2. 2018 оны төсөвт тусгагдсан 670.0 сая төгрөгийг Үндэсний хөгжлийн газраас 2018 оны 9 дүгээр сард “Хөвсгөл геологи” ХХК-д 609.8 сая төгрөгийг олгож, одоогийн байдлаар 60.2 сая төгрөгийг олгоогүй байна. ***/Шилэн данснаас мэдээлэл авсан/***

### *3.3. Нийт хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 40,6 хувьтай байгаа ба үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл арга хэмжээ нь 32,7 хувь буюу хамгийн бага гүйцэтгэлтэй байна.*

3.3.1. ТЕЗ-ийн 2018 оны урсгал болон хөрөнгийн зардлаар зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, аймгийн ИТХ-ын Хурлын хуралдааны 2017 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 06 тоот тогтоол (7 дугаар хавсралт)-оор батлуулсан байна. Мөн аймгийн ИТХ-ын 2018 оны 02 дугаар сарын 07-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан төсвийн тодотголоор худалдан авах ажиллагааны тодотгосон төлөвлөгөөг батлуулсан байна.

3.3.2. 2018 онд БСШУЯ-ны сайдаас 7,780.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл арга хэмжээ, Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны сайдаас 1,197.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл арга хэмжээ, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргаас 1,047.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ Эрүүл мэндийн яамны сайдаас 450.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ, ХХААХҮЯ-ны сайдаас 200.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ Хөвсгөл аймгийн Засаг даргад эрх нь шилжиж ирсэн байна.

3.3.3. 2018 оны эхний хагас жилийн байдлаар тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гэрээ байгуулсан байна. Үүнд:

*ХүснэгтNo-14* */сая төг/*

| № | Үзүүлэлт | Батлагдсан төсөв | Гэрээний дүн | хэмнэлт |
|---|---|---|---|---|
| 1 | Улсын төсвийн хөрөнгө оруулалт | 10,934.0 | 9,575.6 | 1,209.7 |
| 2 | Орон нутгийн хөрөнгө оруулалт | 6,567.1 | 3,556.6 | 355.9 |
| 3 | Орон нутгийн хөгжлийн сан | 4,480.7 | 3,883.1 | 293.2 |
| 4 | Замын сангийн хөрөнгө | 776.7 | 370.5 | 26.2 |
| 5 | Төсөл хөтөлбөр | 248.0 | 225.1 | 22.9 |
| 6 | Урсгал зардал | 19,908.8 | 19,159.1 | 389.2 |
| 7 | БХНСАХЗ | 626.8 | 459.7 | 47.8 |
| 8 | Зөвлөх үйлчилгээ | 627.12 | 327.8 | 12.6 |
| 9 | Засаг даргын нөөц | 71.6 | 12.5 | 0 |
| 10 | Захиалагчийн хяналтын зардал | 55.0 | 48.3 | 6.7 |
| 8 | Нийт | 44295,8 | 37618,3 | 2,364.2 |

2018 оны 3 дугаар улирлын байдлаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажлыг 100 хувь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр нээлттэй ил тод зохион байгуулж, 2,364.2 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гаргасан байна.

3.3.5. Сумдын ТТЗ-д 2018 оны төсвийг батлуулахдаа, ТТЗ-ын тухайн жилд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг сумын ИТХ-аар батлуулж, худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн тайланг улирал тутам аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлж хэвшсэн байна.

3.3.6. 2018 оны эхний хагас жилийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн тайланг аймгийн Санхүү хяналт аудитын албанд хүргүүлээгүй байна. Нөгөө талаас Санхүүгийн хяналт аудитын алба нь Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.1 дахь заалтын дагуу худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн тайланд дотоод хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

3.3.7. Аймгийн Орон нутгийн өмчийн газарт 2018 оны эхний хагас жилд 15 гомдол бичгээр ирсэн байна.Үүнээс тендер шалгаруулалттай холбоотой 13 гомдол ирж 100 хувь шийдвэрлэсэн байна.

3.3.8. ***Хөрөнгө оруулалтын талаар:*** Аймгийн ИТХ-ын 2018 оны хөрөнгө оруулалтын ажлуудыг эх үүсвэр тус бүрээр нь 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 06 тоот тогтоолоор баталсан ба 2018 оны 02 дугаар сарын 07-ний өдрийн 01 тоот тогтоолоор тодотгол хийсэн байна.

*Хүснэгт№-15* */сая төг/*

| № | Эх үүсвэр | 2017.12.04-06 | 2018.02.07-01-тодотгол | Нийт |
|---|---|---|---|---|
| 1 | ОНХС | 4,633.6 | 589.7 | 5,223.3 |
| 2 | ОНХО | 4,512.9 | 958.2 | 5,471.1 |
| 3 | Замын сан | 480.0 | 64.6 | 544.6 |
| *6* | **Нийт дүн** | **9,626.5** | **1,612.5** | **11,239.0** |

***Хүснэгтээс харахад***: 2018 онд хийсэн тодотголоор хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөг 1,612.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.3.9. 2018 оны аймгийн төсвийн төсөлд Төрийн аудитын байгууллагаас хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй холбоотой санал өгөх үед дараах зөрчил дутагдал илэрч байсан. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг нь батлагдаагүй,
- Төсөвт өртөг үнийн дүн зөрүүтэй, магадлал хийгдээгүй
- Аймгийн ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ нь ард иргэдийн санал аваагүй, эрэмбэлэгдээгүй зэрэг болно.

3.3.10. 2018 оны эхний хагас жилийн байдлаар хөрөнгө оруулалтын нийт 538 төсөл арга хэмжээнд 11,239.0 сая төгрөг батлагдсанаас, гүйцэтгэлээр 5,788.9 сая төгрөг гарсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

*Хүснэгт№-16* */сая төг/*

| № | Эх үүсвэр | тоо | 2018 оны 3 дугаар улирал | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөв | Гүйц | Зөрүү | % |
| 1 | Орон нутгийн хөрөнгө оруулалт | 260 | 5,471.1 | 2,967.3 | 2,503.8 | 45,8 |
| 2 | Орон нутгийн хөгжлийн сан | 268 | 5,223.3 | 2,559.8 | 2,663.5 | 50,9 |
| 3 | Замын сан | 10 | 544.6 | 261.8 | 282.8 | 51,9 |
| | **Дүн** | **538** | **11,239.0** | **5,788.9** | **5,450.1** | **48.5** |

**Хүснэгтээс харахад:** Нийт хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 48,5 хувьтай байна.

3.3.11. Хөвсгөл аймагт 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа 5,320.3 сая төгрөгийн төсөл арга хэмжээний эрх шилжиж ирсэн байна. 2018 оны 3 дугаар улирлын байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажил1,740.6 сая төгрөг буюу 32,7 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.3.12. Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, ЗДТГ-ын ХОХБТХ-ээс ирүүлсэн улсын төсөв болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд баригдаж байгаа барилга байгууламжийн гүйцэтгэлийн талаарх мэдээлэл зөрүүтэй байна.

3.3.13. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүдийн тендер шалгаруулалт нь удаашралтай байгаагаас дараах төсөл арга хэмжээ нь хугацаандаа ажлаа эхлээгүй байна. */ХавсралтNº 02-оос харна уу/*

3.3.14. Хөрөнгө оруулалттай холбоотой дараах зөрчил дутагдал илэрч байна. ***Үүнд:***

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл арга хэмжээнүүдийн тендер шалгаруулалт нь удаашралтай байгаагаас орон нутагт хэрэгжих ажлуудын гүйцэтгэл бага хувьтай, хөрөнгө оруулалтын чанар, үр өгөөжид сөрөг үр нөлөө үзүүлэх эрсдэл харагдаж байна.
- Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн барилга шинээр барих төсөл арга хэмжээг анх батлуулахдаа жишиг зургаар батлуулсан ба зураг магадлалаар орж батлагдахад зураг төсвийн зөрүү гарсан, үүнийг яам, барилга хөгжлийн төвийн холбогдох мэргэжилтэнтэй хамтран хуралдаж 2019 оны төсөвт зөрүүг тусгахаар төлөвлөсөн байгаа талаар ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэнгийн ирүүлсэн судалгаанд дурьдсан байна. Энэ нь хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4[8], Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Журам”-ын 3.2[9] заалтыг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүйг харуулж байна.
- Өмнөх онуудад хийгдсэн хөрөнгө оруулалтаас Улаан-уул сумын сургуулийн барилга, Цагаан-үүр сумын сургуулийн барилга гүйцэтгэгчээс шалтгаалан дуусаагүй, Баянзүрх сумын сургуулийн барилга, Алаг-эрдэнэ сумын Соёлын төвийн барилгын ажил дууссан боловч ашиглалтын шаардлага хангахгүй байгаа тул ашиглаагүй, орон нутагт үр өгөөжөө өгч эхлээгүй байна.

Хөрөнгө оруулалттай холбоотой гарсан дээрх зөрчил дутагдлыг харахад: Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 1.7б[10], 1.8а[11],заалтуудыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

### ***3.4. Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрөөр олгосон зээлийн эргэн төлөх үлдэгдлээс 157 иргэнтэй /таалал төгссөн/ холбоотой 136.0 сая төгрөгийг барагдуулах боломж алдагдсан байна.***

3.4.1. Хөвсгөл аймгийн “Хөвсгөл ус суваг” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд Азийн хөгжлийн банкны орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх

*[8] Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.*

*[9] Тухайн санхүүгийн жилд эхлүүлэхээр төлөвлөж буй барилга байгууламж нь 3.1-т заасан зарчмыг баримталсан байхын зэрэгцээ инженер хайгуулийн судалгаа хийж, дүгнэлт гаргасан, **зураг төслийг экспертизээр батлуулсан**, барилга барих газар болон инженерийн шугам сүлжээний асуудлыг бүрэн шийдсэн, үр ашигтай нь техник эдийн засгийн үндэслэл тооцоогоор нотлогдсон зэрэг барилгын ажлыг эхлүүлэх нөхцлийг хангасан, урсгал зардлын урьдчилсан тооцоо хийгдсэн байна*

*[10] 1.7б улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэр, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэгулирлын шинж чанартай төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулан хуулийн дагуу шалгарсан гүйцэтгэгчтэй 2018 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор гэрээ байгуулж, төсөл арга хэмжээний ажил эхлүүлсэн байх:*

*[11] 1.8а улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний байршил, хүчин чадлаас хамааруулан төсөвт өртгийн зөрүүг нягтлах ажлыг Барилга хот байгуулалтын яамтай хамтран 2018 оны 1 дүгээр сарын 15-ний дотор зохион байгуулах:*

төслийн /MON(SF)-1560/ 1,433.9 сая төгрөг, Хот байгуулалтын салбарын /MON 2301/ төслийн 443.4 сая төгрөг нийт 1,877.3 сая төгрөгийг урт хугацаат зээлийн өглөг дансанд бүртгэсэн байна. Дээрх зээлийн хүү болон үндсэн зээлийн эргэн төлөлтийг хийгээгүй ба 2018 оны эхний хагас жилийн байдлаар 475.9 сая төгрөгийн зээлийн хүүгийн өглөг тусгаж тайлагнасан байна.

3.4.2. “Хөвсгөл Эрчим хүч” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд Дэлхийн банкны урт хугацаат зээл “Эрчим хүчний төсөл” /MOG-3503/-ийн хүрээнд 1,152.5 сая төгрөгийг урт хугацаат зээлийн өглөг дансанд бүртгэсэн байна. 2018 оны эхний хагас жилийн тайлангаар үндсэн зээлийн төлбөрт 48.0 сая төгрөг, хүүгийн төлбөрт 4.4 сая төгрөгийг гэрээний дагуу тус тус төлсөн байна.

3.4.3. Хөвсгөл аймагт 1999-2003 онд хэрэгжсэн “Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөр” –ийн хүрээнд ядуу, нэн ядуу, цөөн малтай малчдад 1,221.7 сая төгрөгийн зээл олгож, 2011 онд хүүгийн хамт 1,641.0 сая төгрөг буцааж төлөх гэрээтэй байсан ба ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 124.2 сая төгрөгийн өрийн үлдэгдэл байна.

Дээрх өрийг барагдуулах талаар аймгийн ЗДТГ-аас дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд:

- Сумдын Засаг дарга нарын үр дүнгийн гэрээнд тусгасан
- Зээл барагдахгүй байгаа шалтгааныг тогтоож, зээлдэгчийн талаар судалгаа гаргасан байна.
- Таалал төгссөн 157 иргэдтэй холбоотой 136.0 сая төгрөгийн зээлийг хүчингүй болгож өгөх талаар Сангийн сайд болон ХХААХҮ-ийн сайдад аймгийн Засаг даргын албан тоотыг тус тус хүргүүлсэн ч тодорхой хариу ирүүлээгүй байна.

3.4.5. Аймгийн хэмжээнд малжуулах төсөлд нийт 6 сумын 278 өрх хамрагдаж, 297.5 сая төгрөгийн зээл олгосон байна. 2018 оны эхний хагас жилийн байдлаар 36.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Сумдын ТТЗ нар хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн биелэлтийг тооцож, тайлагнаж хэвшээгүй, түүнд тавих дотоод хяналт хангалтгүй байна.**

# Бүлэг 4

## 4.1. Сумдын ТТЗ нар хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн биелэлтийг тооцож, тайлагнаж хэвшээгүй байна.

4.1.1. Аймгийн засаг дарга нь 2018 онд 16 салбарын сайдтай үр дүнгийн гэрээ байгуулсан байна. Аймгийн Засаг даргын үр дүнгийн гэрээний биелэлтийг 2018 оны эхний хагас жилийн байдлаар холбогдох газар хэлтсүүдээс гаргаж ирүүлсэн боловч ЗДТГ-ын ХШҮДАХ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Журам”-ын дагуу гүйцэтгэлийг тооцож, үнэлээгүй байна.

4.1.2. Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит 5 дугаар хуралдааны 6 дугаар тогтоол /1 дүгээр хавсралт/-оор аймгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр хүрэх үр дүнгийн үзүүлэлт, зорилтот түвшин, зарцуулах хөрөнгийг тооцож баталсан байна.

4.1.3. Сумдын ТТЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр хүрэх үр дүнгийн үзүүлэлт, зорилтот түвшин, тоо, чанарын үзүүлэлт, зарцуулах хөрөнгийг тооцож, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 2 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу

сумын ИТХ-аар батлуулж хэвшээгүй байна. Энэ байдлаас шалтгаалан хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хэрэгжилтийг тоон болон чанарын үзүүлэлтээр нь Засаг дарга нар тодорхой илэрхийлж тайлагнаж чадахгүй байна.

### *4.2. ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар хөтөлбөрийн биелэлт 86,5 хувьтай байна.*

4.2.1. Аймгийн ТЕЗ 2018 онд 26 хөтөлбөр хэрэгжүүлж байна. /2018 оны 3 дугаар улирлын байдлаар /хөтөлбөрийн хэрэгжилт 86,5 хувьтай байна. Хөтөлбөрөөр батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байгаа ч Биологийн төрөл зүйлийн хамгаалалт хөтөлбөр буюу БХНСАХ-ний зардал 46,4 хувь, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр буюу СХС-ийн зээлийн олголт 58,0 хувьтай байна. */Судалгаанаас харах/*

4.2.2. Сумдын ТТЗ-д 2018 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөрөөр нь тайлагнаагүй, хэрэгжүүлж байгаа хөтөлбөр арга хэмжээний биелэлтийг тооцохгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.4[12] дэх заалтыг зөрчиж байна.

### *4.3. Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна.*

4.3.1. Шат шатны төсвийн захирагчдын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, түүний тоо, чанарын үзүүлэлт, зарцуулах хөрөнгийг батлагдсан маягт аргачлалын дагуу бодитой тооцож батлаагүй тул хэрэгжилтийг хянахад хүндрэл учирч байна.

4.3.2. Аймаг, сумдын Засаг даргын хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн үйл ажиллагаанд аймгийн Санхүү хяналт, аудитын албанаас 2018 онд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй ба 2018 оны ажлын төлөвлөгөөнд нэр төрлөөр нь тусгаагүй байна.

***Аудитаар нийт 2,230.0 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэн ба 471.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 86.4 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох санал хүргүүлж, 1,672.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж байна.***

## ДҮГНЭЛТ

***Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:***

1. Аймгийн ТЕЗ-ийн 2018 оны төсвийн хязгаарын саналаа боловсруулж Сангийн яаманд хүргүүлээгүй байна. Тухайн жилийн төсвийн төслийг боловсруулахдаа сумдын ТТЗ буюу Засаг дарга нар харьяалагдах төсвийн шууд захирагч нарын төсвийн төслийг хууль, журмын хугацаанд хүлээн авч нэгтгэхгүй байна.
2. Аймгийн ИТХ-ын 2018 оны 02 дугаар сарын 07-ны 01 тоот тогтоолоор “Давсан орлого дансны үлдэгдэл”-ийг тодотгож баталсан ба энэ нь Төсвийн тухай хуулийн 34.2 дах заалтыг зөрчиж байна.
3. Аймгийн төсвийг төлөвлөхдөө холбогдох тооцоо судалгааг бодит байдалд нийцүүлээгүй, тухайн оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж болон холбогдох

[12] *.хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/*

хууль, тогтоомж, журам, норм нормативыг баримтлаагүйгээс орлогын төлөвлөлттэй холбоотой 1,288.5 сая төгрөг, төсвийн зарлагатай холбоотой 1,529.5 сая төгрөгийн зөрчил тус тус илэрч байна. Төсвийн шууд захирагч нар нь орон тоог хэтрүүлэн ажиллаж байна.

4. Төсөв хүрэлцэхгүй байгаагаас тодорхой хэмжээний өр, авлага үүссэн ба ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үлдэгдэлтэй харьцуулахад авлага 8,4 хувиар, өр төлбөр 20,7 хувиар өссөн байна.
5. Аймаг, орон нутагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудын тоо мэдээлэл зөрүүтэй, холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа хөрөнгө оруулалтыг тухайн ондоо багтааж эхлүүлэх ажил удаашралтай, салбар яамдаас орон нутгийг мэдээллээр бүрэн хангаж ажиллахгүй байгаа зэрэг зөрчил дутагдал байна.
6. ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж, эхний хагас жилд 2,3 тэрбум төгрөгийн тендерийн хэмнэлт гаргасан байна.
7. Сумдын ТТЗ нар хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн биелэлтийг тооцож, тайлагнаж хэвшээгүй, түүнд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

## ЗӨВЛӨМЖ

***Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.***

***Аймгийн ИТХ-ын дарга Л.Төмөрбаатар-т:***

1. Тухайн жилийн төсвийн тодотголыг Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд хэлэлцэн, баталж байх

***Аймгийн Засаг дарга Л.Ганболд-д:***

2. Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 1.1, 7.3 дах заалтуудыг тус тус хэрэгжүүлэн ажиллах
3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, аливаа өр, авлага үүсгэхгүй байхаар үйл ажиллагаагаа зохион байгуулж ажиллах
4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тоон болон чанарын үзүүлэлтээр бодитой тооцон гаргаж байх

***Аймгийн Засаг даргын орлогоч /Эрчим хүчний зохицуулах зөвлөл/-ийн дарга Д.Баттогтох-д:***

5. Орон нутагт мөрдөх дулааны эрчим хүчний үнэ тарифийг батлахдаа бодит тооцоо судалгаанд үндэслэн тогтоох байх

***Сумдын төсвийн төвлөрүүлэн захирагч нарт:***

6. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1 *“төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх”* гэсэн заалт, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 4.3.1, 4.3.2 дах заалтуудыг тус тус хэрэгжүүлэн ажиллах
7. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тоон болон чанарын үзүүлэлтээр бодитой тооцон гаргаж байх

***ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Сувд-д:***

8. Аймгийн төсвийг төлөвлөхдөө бодит тооцоо судалгаанд үндэслэн, Сангийн яамнаас ирүүлсэн тухайн оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж болон холбогдох хууль, тогтоомж, журмыг баримтлан ажиллах
9. Төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах саналыг судлан үзэж тухайн оны төсөвт тусган ажиллах
10. Түлш халаалтын зардалд үүссэн өр, авлагыг 2018 онд багтаан шийдвэрлэж ажиллах

**ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Аззаяа-д:**

11. Тухайн онд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө аймгийн Засаг даргын сайд нартай хийсэн гэрээ болон орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх
12. Хөрөнгө оруулалтын ажлуудын үр өгөөжийг хагас, бүтэн жилээр тооцох, хөрөнгө оруулалтын жагсаалтыг холбогдох байгууллагуудтай тулган, үнэн зөв мэдээлэл боловсруулж, хэрэглэгчдийг бодитой мэдээллээр хангаж ажиллах

***Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын даргыг түр орлон гүйцэтгэгч Б.Ганзориг-т***

13. Хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлд тавих хяналтыг бодитой хэрэгжүүлж, мэдээллийг үнэн зөв боловсруулж ажиллах
14. ЗДТГ-ийн ХОХБТХ болон ОНӨГ-тай уялдаа холбоотой ажиллах

***Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Болдод:***

15. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн тайланд Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Журам”-ын 3.1 дэх заалтын дагуу дотоод хяналт хийлгэж хэвших

***Санхүү хяналт аудитын албаны дарга В.Нэргүй-д***

16. Батлагдсан орог тоо, цалингийн төсөвтөө багтаан ажиллах
17. ТЕЗ-ийн тухайн жилийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн тайланд Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Журам”-ын 4.1, 4.2, 4.3 заалтуудын дагуу үнэлгээ өгөх
18. Шат шатны Засаг даргын хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт хийх

***Галт, Жаргалант, Төмөрбулаг, Рашаант, Бүрэнтогтох сумдын төсвийн шууд захирагч нарт:***

19. Түлш халаалтын зардалд үүссэн өр, авлагыг 2018 онд багтаан шийдвэрлэж ажиллах

**ХавсралтNo-01**

## 2018 оны 3 дугаар улирлын байдлаар зардлуудыг бүлгийн дүнгээр хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбар

**/сая төг/**

| № | Үзүүлэлт | Төлөв | Гүйцэт | Хэмнэлт, Хэтрэлт /+/, /-/ | Шалтгаан, тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цалин хөлс нэмэгдэл урамшил | 30,925.7 | 30,563.8 | 361.9 | • Тариалан, Жаргалант, Цагаан-нуур, Рашаант, Тосонцэнгэл, Түнэл сумдын ТШЗ болон ОН зарим байгууллагууд жирэмсэн болон, өвчтэй чөлөөтэй байсан ажилчдынхаа оронд хүн авч ажиллуулаагүй байна.<br>• Галт, Жаргалант, Эрдэнэбулган, Чандмань-өндөр, Цагаан-үүр зэрэг сумын орон нутгийн орлого тасарч байгаатай холбоотойгоор эх үүсвэр дутуугаас зардлын гүйцэтгэлийг бүрэн хангуулж чадахгүй байна. |
| 2 | Нийгмийн даатгалын шимтгэл | 3,717.4 | 3,651.4 | 65.9 | |
| 3 | Тогтмол зардал | 5,584.7 | 5,167.5 | 417.2 | • Халаалтын зардлын үнийн зөрүүтэй холбоотой гэрээ байгуулаагүй, төлбөрөө бүрэн шилжүүлээгүй байгууллагууд байна.<br>• Нэгдсэн халаалттай газрууд цаг агаарын байдлаас шалтгаалан халаалт авах хоногоо цөөрүүлсэн байна.<br>• Боловсролын салбарын тогтмол зардлын төлөвлөлтийг үндэслэл муутай төлөвлөсөн. |
| 4 | Хангамж, бараа материалын зардал | 1,330.7 | 1,167.1 | 163.7 | • Зарим байгууллагын интернет тасарч ашиглаагүй, төлөвлөснөөс бага үнээр хэрэглэж байгаа тул хэмнэлт гарсан байна. Үүнд: Рэнчинлхүмбэ, Галт гэх мэт<br>• Зарим байгууллагууд дээр нэхэмжлэл болон анхан шатны баримт бүрдээгүйгээс төрийн сангаар гүйлгээ хийгдээгүй байна. |
| 5 | Нормативт зардал | 2,399.8 | 2,190.7 | 209.1 | • Эрүүл мэндийн төвүүдэд хэвтэн эмчлүүлэгчид цөөн байгаа тул хоолны зардал хэмнэгдсэн байна.<br>• Орон нутгийн орлогын төлөвлөгөө тасарч байгаа сумдууд дээр гүйцэтгэл гараагүй байна.<br>• Боловсролын салбарын нормативт зардлын төлөвлөлт хангалтгүй байна. |
| 6 | Эд хогшил урсгал засварын зардал | 749.2 | 572.5 | 176.7 | • Гэрээ байгуулж, ажил хийгдэж эхэлсэн ч гүйцэтгэл гараагүй тул хүлээгдэж буй гүйцэтгэл байна.<br>• Орон нутгийн орлогын төлөвлөгөө тасарч байгаа сумдууд дээр гүйцэтгэл гараагүй байна |
| 7 | Томилолт зочны зардал | 158,8 | 124,2 | 34.6 | • Орон нутгийн өмчийн газар дээр хөрөнгийн дахин үнэлгээний ажил эхлээгүй байгаа тул зардлын гүйцэтгэл гараагүй байна. |
| 8 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил | 1,816.4 | 1238.6 | 577.8 | • Энэ ажил гүйлгээнд аймаг сумдын ГХУСАХЗ, БХНСАХЗ, СХС-ын үндсэн үйл ажиллагааны зардал, Соёлын байгууллагуудын уран бүтээлийн зардал, засаг дарга данснаас ахмадын хорооны зардал, ангилагдаагүй бусад арга хэмжээний зардал, мал хамгаалах сангийн төсөв зэрэг зардлууд багтаж байна.<br>• Нийт үлдэгдлийн 44,9 хувь нь БХНСАХЗ байгаа ба тус ажлуудын гүйцэтгэл дутуугаас мөнгө олгогдоогүй байна. |
| 9 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,094.3 | 1,582.9 | 511.4 | • Эмнэлгийн тусламж үйлчилгээний зардал, боловсролын нүүдлийн бүлэг, явуулын багшийн үйлчилгээ, биеийн тамир арга хэмжээний зардал, хөтөлбөрийн болон нөөц хөрөнгийн зардлууд багтаж байна.<br>• Хөтөлбөрийн үлдэгдэл 265.4 сая төгрөгийн гүйцэтгэл гараагүй байна.<br>• Хичээл үйлдвэрийн дадлага зардлын гүйцэтгэл хичээлийн жилийн үйл ажиллагаа жигдрээгүй байгаа тул үлдэгдэл нилээд байна. |
| 10 | Татаас | 635.9 | 534.8 | 101.1 | • Хувийн сургууль цэцэрлэг болон усны алдагдалд олгож байгаа зардал багтаж байна.<br>• Усны алдагдлын татааст олгох санхүүжилтийг шилжүүлээгүй байна. |
| 11 | Урсгал шилжүүлэг | 19,322.4 | 18,136.8 | 1,185.6 | • Халамжийн үйлчилгээний хоол тэжээлийн нэмэгдэлд гүйцэтгэл бага гарсан байна.<br>• Сургуулийн хүүхдийн ирцээс хамаарч Үдийн цай хөтөлбөрийн зардал тодорхой хэмжээгээр хэмнэгдсэн байна.<br>• Бэлтгэн нийлүүлэгчдээс хүнсний материал авсан ч гүйлгээ хийхгүй сар дуусгасан тохиолдол байна.<br>• Төрийн албан хаагчдад олгох 300.0 мянган төгрөгийн урамшуулал зарцуулагдаагүй байна. |
| 12 | Хөрөнгийн зардал | 6,746.7 | 4,831.1 | 1,915.6 | • Батлагдсан ажлуудын гүйцэтгэлээс хамаарч зардлын гүйцэтгэл хангагдаагүй байна. |
| 13 | Эргэж төлөгдөх зээл | 2,182.6 | 1,282.9 | 899.7 | • Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс зээл олголтын гүйцэтгэл бага байна. |

***Хавсралт№-02***

## *2018 оны 9 дүгээр сараас хойш гэрээ байгуулж, ажил нь эхэлсэн төсөл арга хэмжээний жагсаалт*

***/сая төг/***

| № | Арга хэмжээний нэр | Төсөвт өртөг | 2018 онд санхүүжих | Хөрөнгийн эх үүсвэр | Гэрээ байгуулсан байдал |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цэцэрлэгийн барилга /Хөвсгөл аймаг, Түнэл сум/ | 1,500.0 | 750.0 | Улсын төсөв | Гүйцэтгэгчээр МОМ марс ХХК шалгарч 2018 оны 10 дугаар сарын 24-нд гэрээ байгуулсан байна. Ажлын гүйцэтгэл -10% |
| 2 | Цэцэрлэгийн барилга /Хөвсгөл аймаг Тариалан сум -150 ортой/ | 1,800.0 | 500.0 | Улсын төсөв | Гүйцэтгэгчээр Их үен ХХК шалгарч, 2018 оны 9 дүгээр сард гэрээ байгуулж, ажил эхэлсэн. Ажлын гүйцэтгэл – 20% |
| 3 | Захирагчийн албаны барилга /Хөвсгөл аймаг Алаг-эрдэнэ сум Хатгал тосгон/ | 1,012.0 | 512.0 | Улсын төсөв | Гүйцэтгэгчээр ХБС ХХК шалгарч 2018 оны 9 дүгээр сарын 25-нд гэрээ байгуулж, ажил эхэлсэн. Ажлын гүйцэтгэл- 30% |
| 5 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Хөвсгөл Галт сум/ | 200.0 | 200.0 | Улсын төсөв | Гүйцэтгэгчээр нь Хөвсгөл булаг ХХК шалгарч 2018 оны 9 дүгээр сарын 20-нд гэрээ байгуулан ажил эхэлсэн байна. Ажлын гүйцэтгэл – 50% байна. |
| 6 | Халдварт, сүрьеэгийн эмнэлгийн барилга, 30 ортой / Хөвсгөл, Мөрөн сум/ | 2,037.6 | 500.0 | Улсын төсөв | Гүйцэтгэгчээр Beg Mongolia building ХХК шалгарч 2018 оны 10 дугаар сарын 22-нд гэрээ байгуулж ажил эхэлсэн. Ажлын гүйцэтгэл - 10% |
| 7 | Эрүүл мэндийн төвийн барилга /Хөвсгөл Шинэ-идэр сум / | 1,440.0 | 500.0 | Улсын төсөв | Гүйцэтгэгч “Мөрөн Алтай” шалгарч 2018 оны 7 сарын 20-нд гэрээ байгуулж ажил эхэлсэн. Анх зураг батлуулахдаа жишиг зургаар батлуулсан ба зураг магадлалаар орж батлагдахад зураг төсвийн зөрүү гарсан, үүнийг яам, барилга хөгжлийн төвийн холбогдох мэргэжилтэнтэй хамтран хуралдаж 2019 оны төсөвт зөрүүг тусгахаар төлөвлөсөн байна. |
| 8 | Нийт | 7,989.6 | 2,962.0 | | |

# Зөрчлийн жагсаалт

**/сая төг/**

| № | Аудитаар илэрсэн | | Өгсөн албан шаардлага | | Тавьсан акт | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Зөрчлийн утга | Зөрчлийн дүн /сая төг/ | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн |
| 1 | Тухайн жилийн төсвийн төслийг боловсруулахдаа сумын ТТЗ буюу Засаг дарга нар харьяалагдах төсвийн шууд захирагч нарын төсвийн төслийг хууль, журмын хугацаанд хүлээн авч нэгтгэхгүй байна. | | | | | | 1 | |
| 2 | Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 заалтын дагуу аймгийн ТЕЗ-ийн 2018 оны төсвийн хязгаарын саналаа боловсруулж Сангийн яаманд хүргүүлээгүй байна. | | | | | | 1 | |
| 3 | Аймгийн 2018 оны төсөвт тодотгол хийсэн нь Төсвийн тухай хуулийн 34.2-т заасан нөхцөл байдалтай нийцэхгүй байна. | | 1 | | | | | |
| 4 | Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-т заасан хувь хэмжээгээр тооцож төлөвлөөгүй байна. | 595.6 | | | | | 1 | 595.6 |
| 5 | Сумдын ТТЗ-д Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т заасан хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна. | 250.6 | | | | | 1 | 250.6 |
| 6 | 2018 оны орлогын төлөвлөгөөнд ойн нөөц ашигласны төлбөрийн орлого биелэгдэх боломжгүй болсон байна. /Энэ жил самар ургаагүй байна./ | 690.7 | | | | | 1 | 690.7 |
| 7 | “Хөвсгөл Эрчим хүч” ХХК-аас хог хаягдлын хураамжийн орлогыг дутуу төвлөрүүлсэн. | 75.0 | | | | | 1 | 75.0 |
| 8 | “Могойн гол” ХК-аас 2018 онд төвлөрүүлэх хувьцааны ногдол ашиг төвлөрүүлээгүй | 18.5 | | | | | 1 | 18.5 |
| 9 | Галт, Жаргалант, Төмөрбулаг, Рашаант, Бүрэнтогтох сумдын төсөвт байгууллагууд халаалтын зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлэн гэрээ байгуулж, эхний 9 сарын байдлаар өр үүсгэсэн байна | 471.2 | 1 | 471.2 | | | | |
| 10 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэмжээнд 2018 оны эхний хагас жилийн байдлаар 9 орон тоо хэтрүүлэн ажиллаж байна | 52.5 | | | | | 1 | 52.5 |
| 11 | ЗГ-ын 2016 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 09 дүгээр тогтоолын 1-д аймгийн Засаг даргын орлогчийг 1 байхаар заасан байтал тус аймагт 2 орон тоогоор ажиллаж байна. | 33.9 | | | | | 1 | 33.9 |
| 12 | Аймаг, орон нутагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудын тоо мэдээлэл зөрүүтэй, холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа хөрөнгө оруулалтыг тухай ондоо багтааж эхлүүлэх ажил удаашралтай, хийгдэж байгаа хөрөнгө оруулалтууд нь үр өгөөжөө өгч эхлээгүй зэрэг зөрчил байна. | | | | | | 1 | |
| 13 | Сумдын ТТЗ-д 2018 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөрөөр нь тайлагнаагүй, хэрэгжүүлж байгаа хөтөлбөр арга хэмжээний биелэлтийг тооцохгүй байна. | | | | | | 1 | |
| 14 | Аймаг, сумын Засаг даргын хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна | | | | | | 1 | |
| 15 | 2018 оны төсвийн төсөлд Хөвсгөл аймаг дах Төрийн аудитын газраас дараах 160,0 гаруй сая төгрөгийн орлогыг нэмэгдүүлж төлөвлөх боломж байгаа талаар санал хүргүүлж байсан болно. | | | | | | 1 | |
| 16 | Улаан-уул, Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн цалинг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс өр төлбөр үүссэн байна. | 42.0 | | | | | 1 | 42.0 |
| | ***Нийт дүн*** | ***2,230.0*** | ***2*** | ***471.2*** | | | ***14*** | ***1,758.8*** |

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2018 оны 11 сарын 05 өдөр | Дугаар А/47 | Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, 2017 оны А/188 дугаар тушаалын тавдугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу "2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг батлсугай.
2. Аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн хяналт, аудитын албанд тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2019 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Л.Ганболд), аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Сувд), Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга (В.Нэргүй) нарт зөвлөсүгэй.
5. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер (Ж.Отгончимэг), ахлах аудитор (Б.Тэгшдэлгэр) нарт даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.ГАНБОЛД

Data tushaal2018

1551147

## Холбогдох байгууллагын санал:

<table>
<tr><th>Ирүүлсэн санал</th><th>Хариу</th></tr>
<tr><td>


АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА О.ГАНБОЛДОД

ХЭНТИЙ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА

2018.11.02 № 1/162

Хүсэлт хүргүүлэх тухай

Таны байгууллагаас гүйцэтгэж байгаа "2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Бүлэг 3-ын 3.2.14-т "Орон тоог хэтрүүлэн ажилласнаас СХАА нь [illegible]" гэсэн дүгнэлттэй бид санал нийлэхгүй байна. Манай байгууллага нь орон нутгийн төсвийн [illegible] аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Б/08 тоот захирамжаар батлагдсан 9 орон тоондоо багтаж ажиллаж байгаа. Орон тоо хэтрүүлсэн асуудал байхгүй.

Монгол улсын Сангийн сайдын тушаалаар "Улсын салбарын дотоод аудитыг хөгжүүлэх дунд хугацааны стратеги" [illegible] улсын байгууллагын [illegible] ТЕЗ болон дотоод аудитын албаны дарга нар [illegible] мэдэгдэн.

Мөн Засгийн газрын 2015 оны 485 тоот тогтоолоор батлагдсан Дотоод аудитын журмын 5.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч нь дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт болон уг үйл ажиллагааг баримтжуулалтад зайлшгүй хэрэглэх техник, тоног төхөөрөмж, [illegible]" гэсэн байдаг. Түүний дагуу жил бүр Сангийн яамнаас батласан дээд хязгаарт 27.0 сая орчим төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс авч үйл ажиллагаа явуулж ирсэн. Энэ нь аймгийн Засаг дарга буюу аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1, 42 дугаар зүйлийн 42.2 дугаар зүйлд заасан эрхийнхээ хүрээнд шийдвэрлэж ирсэн асуудал бөгөөд [illegible] асуудал юм.

2018 оны цалин, НДШ-ийн зардалд хуваарилагдсан байгаа гүйцэтгэлээр 15.1 сая төгрөг дутагдаж байгаа ба энэ онд [illegible] нийт 4 [illegible] нийт 9.2 сая төгрөг хэмнэсэн ба одоо 7 орон тоотой ажиллаж байгаа болно.

[illegible] холбоотой батлагдсан орон тоондоо тохирсон төсөв батлуулах талаар Сангийн яаманд удаа дараа хүсэлт тавьсан боловч орон нутгийн байгууллага учраас аймгийн ТЕЗ-аар шийдвэрлүүл гэсэн хариу өгч ирсэн болно.

ДАРГА В.НОРГУЙ
</td><td>1. 2018 оны батлагдсан орон тоо, гүйцэтгэлээс зөрүүтэй, 2018 оны сүүлийн 3 сард төсөв хүрэлцэхгүй байгаа нь баримтаар нотлогдож байгаа тул санал хүлээн авах боломжгүй байна.</td></tr>
</table>

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР

67123 Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Уран дөш баг
Утас: 70382918
Э-mail: www.khovsgol.gov.mn

________ № ________
танай ________ ны № ________-т

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн” санхүүгийн аудитын тайлангийн төсөл, “2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд холбогдох тайлбарыг хүргэж байна.

Хавсралт ... хуудас

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Г.СУВД

| | |
|---|---|
| **"2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц"**<br>**санхүүгийн аудитын тайланд өгөх тайлбар /ОНО/**<br><br>**Бүлэг:1** 1.2.14. Аудитаар төсвийн төлөвлөлттэй холбоотой дараах зөрчил илэрч байна. Үүнд:<br>• Ойн нөөц ашигласны төлбөр/самрын орлого/-ыг суурь судалгаанд үндэслэлгүйгээр 670,0 сая төгрөг төлөвлөсөн байна.<br><br>**Тайлбар:1 Ойн нөөц ашигласны төлбөр/самрын орлого/-ыг суурь судалгаанд үндэслэлгүйгээр 670,0 сая төгрөг төлөвлөсөн гэж тайланд бичсэн аймаг уу эсвэл Сангийн яам уу гэдэг нь тодорхойгүй байна. Хэрэв Сангийн яамыг хэлж байгаа бол Сангийн яам гэж тодруулж бичмээр байна. Хэрэв аймаг төлөвлөсөн гэж бичиж байгаа бол үүнийг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд энэхүү хүлээн зөвшөөрөхгүй байгаа шалтгаан тайлбараа Сангийн яамны 2018 оны орон нутгийн төсвийн орлогын хяналтын хуудас болон албан бичиг, дараах тайлбаруудаар хүргэж байна. Үүнд:**<br><br>Хушны модны самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэснээс орох орлогыг Сангийн яамнаас 690,8 сая төгрөгөөр тооцон нэмсэнийг 2018 онд орох боломжгүй байгаа тул төсвийн тодотголоор санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлж өгөх Аймгийн Засаг даргын 2018-01-30-ны өдрийн 1/253 дугаар албан бичгийг Сангийн сайдад хүргэсэн. /Албан бичгийг хавсаргав./<br><br>Сангийн сайдын 2018-03-01-ний өдрийн 4-2/983 дугаар албан бичгээр "Хушны модны самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэснээс орох орлогыг өнгөрсөн онуудын гүйцэтгэл, холбогдох байгууллагуудаас ирүүлсэн /БОАЖЯ/ мэдээлэлд үндэслэн тооцсон. Хушны модны самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэснээс орох орлогын гүйцэтгэл гараагүй байгаа энэ үед орлогын тасалдах боломжтой эсэхийг тооцоход эрт бөгөөд тодорхой гүйцэтгэл гарсны дараа уг орлогын төлөвлөлтөд эргэн харах боломжтой болох юм." гэсэн хариу ирж байсан. /Албан бичгийг хавсаргав./<br><br>Самрын орлоготой холбоотой Сангийн сайдад Аймгийн Засаг даргын 2018-08-06-ны өдрийн 1/1740, 2018-09-10-ны өдрийн 1/1942, 2018-10-12-ны өдрийн 1/2219 дугаар албан бичгүүдийг хүргүүлсэн. /Албан бичгийг хавсаргав./<br><br>Сангийн сайдаас 2018-10-08-ны өдрийн 4-2/6351 албан бичгээр ЗГ-ын 2017 оны 337 дугаар тогтоолын 1.5 дах хэсэгт "Засгийн газраас ...." гэж заасны дагуу батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа зохицуулан ажиллана уу гэсэн хариу ирсэн.<br><br>Аймгийн Засаг даргын 2018-10-30-ны өдрийн 1/2369 албан бичгээр "... Тухайн сумд батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй байдалд хүрсэн нь тухайн сумдын орон нутгийн орлого, зарлагын гүйцэтгэл, ЖБГ-аас харагдаж байгаа тул ... "Төсвийн тухай" хуулийн 34.2.2 заалтыг үндэслэн аймгийн төсөвт тодотгол хийх боломж байгаа эсэх" талаар Сангийн сайдад хүсэлтийг хүргэсэн байна.<br><br>**Сангийн яамнаас нэмж хянасан самрын орлого 690,8 сая төгрөгийн үндэслэлгүй төлөвлөлтөнд аймаг хамааралгүй болох нь 2018 оны орон нутгийн төсвийн орлогын хяналтын хуудас, албан бичиг, дээрх тайлбаруудаас харагдаж байгаа энэхүү заалтаа хасна уу. Эсвэл Сангийн яам орлогыг үндэслэлгүй хянаж байгаа нь орон нутгийн төсвийг хүндрүүлж байгаа талаар тодорхой бичнэ үү** | ***Санал-1-д***<br>Саналыг хүлээн авч тайланд “... орон нутгийн саналыг харгалзахгүйгээр Сангийн яам ойн нөөц ашигласны төлбөрийг 690.7 сая төгрөгөөр нэмж хянасан байна.... гэж тайланд өөрчлөлт оруулав. |



• Шинэ-Идэр суманд ургамлын нөөц ашигласны төлбөрт 2,2 сая төгрөг үндэслэлгүй төлөвлөсөн байна.

**Тайлбар:2 Шинэ-Идэр сумын ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогыг 670 кг зэх нэрсээс экологи эдийн засгийн үнэлгээгээр тооцон 2,2 сая төгрөгийг төлөвлөсөн бөгөөд энэ жил Галт, Жаргалант, Шинэ-Идэр сумдад нэрс жимсний ургац сайн гарсан тул энэхүү орлогыг үндэслэлгүй төлөвлөсөн гэж үзэхгүй бна.**

• Бүлэг 1. 1.2.14. заалт: ...Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-т заасан хувь хэмжээгээр тооцож төлөвлөөгүйгээс 596,6 сая төгрөгийг дутуу тооцсон байна.

**Тайлбар:3** Хуш модны самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэснээс орох орлогыг Сангийн яамнаас 690,8 сая төгрөгөөр тооцон манай аймгийн ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг нэмэгдүүлэн тооцсоныг **Тайлбар-1-д** дэлгэрэнгүй дурдсан.

Энэхүү Сангийн яамнаас нэмэгдүүлсэн 690,8 сая төгрөгийн ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос /самрын орлого/ байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах 85 хувь буюу 587,2 сая төгрөгийн орлогыг тооцоогүй үндэслэн. Самар ургасан тохиолдолд тухайн сумдад гүйцэтгэлээр тооцон нэмэгдүүлэх тухай 2018 оны төсвийн төсөлд тусгасан. Хэрэв 2018 оны төсөв батлах үед энэхүү самрын орлого 690,8 сая төгрөгөөс байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах 85 хувь буюу 587.2 сая төгрөгийн орлогыг нэмэгдүүлэн төлөвлөж батлагсан бол тухайн сумдын байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогын тасалдал үүсч төсвийн хүндрэлийг улам нэмэгдүүлэх байсан.

**Энэхүү самрын орлогыг хасч байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийг тооцсон нь самрын орлогын тасалдлаас үүсэх төсвийн хүндрэлийг бууруулсан чухал алхам гэж үзэж байгаа тул энэхүү зөрчлөөс хасч өгнө үү.**

**Аймгаас 2018 оны төсвийн төсөлд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-т заасан хувь хэмжээгээр Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос /үндэслэлгүй нэмсэн самрын орлогыг хасч/ зохих хувь хэмжээгээр бүрэн тооцож сумдад хүргүүлсэн болно.**

**Бүлэг:2**

• **2.1.4. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр: Үндэслэлтэй төлөвлөөгүйгээс гүйцэтгэл тасарч байна.**

**Тайлбар:4** Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлнө гэж заагдсан байдаг. Манай аймагт Хөвсгөл геологи элс, улаан шавар, Цагаанчууд констракшн ХХК дайргаар түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Энэхүү 2 компаний үйл ажиллагаа тогтмол биш, нийт сумдад хүрч ажиллах боломжгүй байдал нь энэхүү орлогын тасалдлыг үүсгэж байна. Хэрэв тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үйл ажиллагаа тогтмол, нийт сумдад хүрч үйлчилвэл 2018 онд төлөвлөсөн түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн орлого 28,8 сая төгрөг бүрэн төвлөрөх боломжтой талаар өмнө хүргүүлсэн орлогын тасалдлын тайлбарт дурдсаныг дахин хүргэж байна.

***Санал-2-т***
Шинэ-идэр суманд ажиллаж холбогдох тооцоо судалгаа үзэж, албан тушаалтантай уулзаж ярилцсан тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

***Санал -3-т:***
Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний төсвийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу тооцох тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

***Санал -4-т:***
Хүлээн авах боломжгүй байна.

Харин аймгийн хэмжээнд хийгдэж байгаа бүтээн байгуулалтуудад бүгдэд нь элс хайрга зэрэг түгээмэл тархацтай ашигт малтмалуудыг ашиглаж байгаа хэдий ч эдгээрийг тооцон төсвөт төвлөрүүлэх байгууллагуудын үйл ажиллагаа сул байна гэж бидний зүгээс үздэг бөгөөд орлогыг тооцон төвлөрүүлэх талаар шахаж ажилладаг.

**Иймд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь тогтмолжуулах, талаар тайланд тусгана уу.**

**2.2. 2018 оны орон нутгийн төсвийн орлогыг 160,0 гаруй сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.**

- Аймаг, сумдад үйл ажиллагаа явуулж байгаа ОНӨҮГ-ын ашгаас 100,0 орчим сая төгрөгөөр аймаг, сумын орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх санал байна.

**Тайлбар: 5** Орон нутгийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниудын хувьцааны ногдол ашиг хуваарилах шийдвэрийг "Компанийн тухай" хуулийн 47 дугаар зүйлд заасан нөхцөлийг хангаж байгаа тохиолдолд компаний ТУЗ-өөс шийдвэр гаргаж хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулдаг.

Төсвийн тухай хуулийн 23.7.1, 23.9.1 орон нутгийн төсөвт төвлөрүүлэх заалтаар компаниудын төлөвлөн удирдах зөвлөлөөс гарсан саналыг хувьцаа эзэмшигчдийн хурал буюу аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэдэг.

**Иймд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн ногдол ашиг орон нутгийн төсөвт төвлөрдөг тул аймгийн ИТХ-д энэхүү заалтаа зөвлөмжөөр өгнө үү.**

- **Цагдаагийн байгууллага галт зэвсгийн бүртгэл, хөдөлгөөний мэдээг Татварын албанд ирүүлбэл бууны татварын орлогыг бодитой төлөвлөх, ингэснээр орлогыг 10 орчим сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.**

**Тайлбар: 6** Бууны албан татварыг 2017 онд 77,2 сая төгрөгөөр төлөвлөснөөс 74,0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй орлого 3,2 сая төгрөг буюу 95,9 хувийн биелэлттэй гарсан.

2018 онд Сангийн яамнаас 78,0 сая төгрөгөөр баталсныг 76,9 сая төгрөг болгон 1,1 сая төгрөгөөр сумдын ИТХ-аар бууруулж баталсан. 2018 оны эхний 09 сарын байдлаар 50,3 сая төгрөгийн төлөвлөлөөтэйгээс 48,8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буу орлого -1,5 сая төгрөг буюу 97 хувийн биелэлттэй.

СТСХ-оос аймгийн ЗД-ын удирдамжийн дагуу сумдад хяналт шалгалтаар ажиллахдаа орон нутгийн орлого төлөвлөлт, аудитын зөвлөмжийн дагуу орлого нэмэгдүүлэх ажлын төлөвлөгөө гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан бөгөөд Цагдаагийн байгууллагаас сумдад хүргэсэн галт зэвсгийн бүртгэл хөдөлгөөнийг зарим сумдад татварын байцаагчтай тулгалт хийж үзэхэд бууны шилжилт хөдөлгөөн, хасалтаа бүртгээгүй, давхардсан бүртгэл байсан нь бууны тоо нэмэгдэх биш, хасагдах байдал Цагдаагийн газрын галт зэвсгийн бүртгэл судалгаанд байгаа нь харагдаж байсан.

**Иймд Бууны албан татварын орлогыг 10,0 орчим сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжгүй юм.**

**Хөвсгөл аймгийн 2018 оны төсвийг үндэслэлгүй төлөвлөөгүйгээс орлогын 1267,8 сая төгрөгийн зөрчил илэрсэн гэж тайланд тусгагдсаныг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа дээрх**

***Санал -5-т:***
Хүлээн авах боломжгүй байна.

**Хөвсгөл аймгийн 2018 оны төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс орлогын 1267,8 сая төгрөгийн зөрчил илэрсэн гэж тайланд тусгагдсаныг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа дээрх тайлбаруудаар хүргэж байгааг харгалзан үзэж тайлангийн төсөл болон холбогдох зөвлөмжинд өөрчлөлтийг оруулна уу.**

- Ус ашиглагч... мал... УТХ ... 50,0 орчим сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэх боломж байна.

**Тайлбар:** Аймгийн Аудитын газраас 2017 онд "Орон нутгийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, татвар хураалтын байдал, үр дүн" гүйцэтгэлийн аудитыг хийгдсэн. Энэхүү гүйцэтгэлийн аудитын зөвлөмжинд дээрх 2 заалт тусгагдсан байсан. Энэхүү гүйцэтгэлийн Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, гарсан зөрчлийг арилгах, орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх талаар арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж Аймгийн Засаг даргаар батлуулан, аймгийн Засаг даргын 2017-09-15-ны өдрийн 1/2031 албан бичгээр бүх сумдад хүргэсэн. Энэхүү арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг тооцож, зохион байгуулсан ажлын гүйцэтгэлийг ирүүлэх талаар аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн даргын 2017-10-04-ний өдрийн 8/2218, 2018-02-23-ний өдрийн 8/413 дугаар албан бичгийг сумдад хүргүүлж зөвлөмжийн дагуу нэмэгдүүлэх санаачлагыг нэгтгэн төсөвт тусгасан. Малын гаралтай түүхий эдийн худалдан борлуулах болон мал ... үүсэл чанарыг тодорхойлон гэрчилгээ олгоход УТХ-ийн тухай хуулийн 35.1.21 заалтын дагуу 13970,0 мянган төгрөг, Ус ашиглагчтай гэрээ байгуулан гэрчилгээ олгоход хураах УТХ-ийн орлогыг 785,0 мянган төгрөгөөр тус тус нэмж баталсан.

**Иймд аймгийн Аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийн хүрээнд дээрх ажлуудыг хийж хэрэгжүүлсэн нийт 14755,0 мянган төгрөгийг ОНО-ын төлөвлөгөөнд нэмж тусган баталсан тул дахин нэмэгдүүлэн төлөвлөх шаардлагагүй гэж үзэж байна.**

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Сувд

Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Х.Энхтуяа



*Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад хийсэн аудитын тайлангийн төсөлд өгөх тайлбар мэдээлэл. /Заргам/*

1 ДҮГЭЭР БҮЛЭГ.

**1.1.3. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй**

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарын санал хүргэх ажил асуудал нь Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газар, УИХ-ын дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, шадар сайд, Үндсэн хуулийн цэцийн дарга.Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, яамдууд болон тэдгээртэй адилтгах бусад субъектийн түвшинд хийгдэж байгаа бөгөөд аймаг орон нутагт ирж байгаа санхүүгийн дэмжлэг, ТЗШ-ийн байгууллагуудын санхүүжилт, ОНХС-ийн санхүүжилтүүд, орон нутгийн орлогын суурь тооцооллууд бүгд дээрх яамдаас хүргэгдэж байгаа төсвийн хязгаарын саналд багтаж байгаа бөгөөд орон нутгийн төсвийн төслийг Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалаар батлагдсан "орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын дагуу боловсруулан ажиллаж байна.

Та бүхний тавьсан асуудлын талаар сангийн яамнаас тодруулахад орон нутаг дээрх тушаалыг баримтлах бөгөөд дунд хугацааны төсвийн төлөвлөлтийг 3 жилээр тооцон хянуулсан төсвийн төсөлд үндэслэн хязгаарыг тооцдог болох талаар хариу өгсөн болно. Албан бичгээр удаагүй албажуулж өгүүлнэ гэсэн бөгөөд Төсвийн тухай хуулийн 8.3.1 заалт нь орон нутгийн ТЕЗ-д хамааралгүй, орон нутгийн төсвийг орон нутгийн ИТХ-ын хуралдаанаар баталдаг учраас уг заалтын дагуу төсвийн хязгаарын санал хүргэдэг орон нутгийн ТЕЗ байхгүй байна.

**1.1.5. Тухайн жилийн төсвийн төслийг боловсруулахдаа сумын ТТЗ-ийн төсвийн төслийг авч нэгтгээгүй**

Тайлбар: Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчид дараа жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаарсарын 25-ны дотор харьялах дээд шатны байгууллага буюу аймгийн боловсрол, соёл, спортын газар болон эрүүл мэндийн газарт хүргэн нэгтгэгдэж, аймгийн засаг даргад танилцуулан албан бичгийг хамтаар ТЕЗ буюу холбогдох яамдад хүргэж байна.

2019 оны төсвийн төсөл боловсруулах удирдамжийн дагуу ТЗШ-ийн байгууллагуудын төсвийн төслийн нэгтгэл, тогтмол зардлын тооцооллын 2018 оны 7 дугаар сарын 25-ны дотор холбогдох газруудаас авч төлөвлөлтийн онлайн системд шивж Сангийн яаманд хянуулсан болно.

**1.1.8. 2018 оны төсвийн тодотголыг Сангийн сайд хүлээн авч шийдвэрлэх боломжгүй талаар уламжилсан ...**

Тайлбар: Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаМонгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "б" дахь заалт, "Төсвийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 57 дугаар зүйлийн 57.3, 56 дугаар зүйлийн 56.2.1, 60 дугаар зүйлийн 60.2.4, 64 дугаар

***Санал -6-т:***
Төсвийн тухай хуулийн 8.3.1-д тодорхой заасан тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

***Санал -7-т:***
Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан "Журам"-д тодорхой заасан тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

***Санал -8-т:***
Санал хүлээн авч /.... Сангийн яам 2018 оны 8 дугаар сард төсвийн тодотголыг хүлээн зөвшөөрч зарцуулах эрхийг нээж өгсөн гэж байгаа боловч нотлох баримт байхгүй байна.
...../ тайланд өөрчлөлт оруулав.

<table>
<tr>
<td>
зүйлийн 64.1.2 дах заалтуудыг үндэслэн 2018 оны 2 дугаар сард "2017 оны давсан орлого, дансны үлдэгдэл"-ийг зарцуулах шийдвэрийг гаргасан.<br><br>
Сангийн яамнаас 5 дугаар сард тухайн асуудлыг хүлээн авах боломжгүй талаар албан бичиг ирүүлсэн хэдий ч яам, Засгийн газрын түвшинд асуудлыг дахин авч үзээд төсвийн тухай хуулийн 57.3 дах заалтыг үндэслэн, мөн олон улсын валютын сантай зөвшилцсөний дагуу аймаг орон нутаг нь өмнөх оны дансны үлдэгдэл, давсан орлогыг зарцуулж болох чиглэл өгч зарцуулалтын эрхийг нээсний дагуу батлагдсан зардал, арга хэмжээнүүдэд зарцуулж байна. Дээрх зөвшөөрлийг албан бичгээр ирүүлэх хүсэлтийг Сангийн яаманд илгээсэн байгаа болно.<br><br>
1.2.14. ... Халаалтын зардлыг 1738 төгрөг буюу өмнөх оны суурь үнээс 308 төгрөгөөр нэмэгдүүлэн тооцсон<br><br>
Тайлбар: Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 7 дугаар сард гарсан 190 дугаар тогтоолоор манай аймгийн төвийн төсөвт байгууллагуудад мөрдөгдөх дулааны нэгж тарифыг суурь үнээс 286 төгрөгөөр нэмэгдүүлж тухайн жилийн 9 дүгээр сарын 15-наас мөрдөхөөр, аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2017 оны 8 дугаар сард гарсан 04 дүгээр тогтоолоор төсөвт байгууллагуудад мөрдөгдөх нэгж тарифыг суурь үнээс 308 төгрөгөөр нэмэгдүүлэн баталж 2018 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөхөөр батлагдсан бөгөөд дээрх шийдвэрүүд өнөөг хүртэл хүчин төгөлдөр хэвээр байна.<br><br>
Харин 2018 оны төсвийн төслийг Сангийн яаманд хянуулахад нэмэгдсэн тарифаар тооцож төлөвлөөгүй, асуудлыг холбогдох яам, газар, албан тушаалтанд уламжлаагүй байсан бол тухайн асуудал бүр хурцдаж, үүсч байгаа эс, ярилцаж байгаа бүх асуудал, алдаа дутагдал, хариуцлага зөвхөн санхүүгийн хэлтэс, түүн дотроо төлөвлөлтийн маш том алдаа болох байсан. Түүгээр ч зогсохгүй төрийн аудитын байгууллагаас "тариф нэмэгдүүлсэн хүчин төгөлдөр шийдвэрүүд байхад нэмэгдүүлж тооцоогүй, төлөвлөөгүй нь санхүүгийн хэлтсийн хариуцлагагүй байдал, төлөвлөлтийн алдаа байна" гэж дүгнэгдэх нь тодорхой юм.<br><br>
... Зарим сургуулийн цалингийн зардлыг дутуу төлөвлөсөн<br><br>
Тайлбар: Жаргалант сумын сургуулийн цалин 25.0 сая, Улаан-Үүл сумын сургуулийн цалин 17.0 сая тус тус дутуу төлөвлөсөн байгаа нь тус сургуулиудад 2017 оны гүйцэтгэлээс хүүхдийн тоо нэмэгдсэнээр бага анги нэмэгдсэн, цагийн ачаалал болон багшийн тоо нэмэгдсэн зэргээс хамаарсан. Төсөв хуваарилах үед дээрх мэдээллүүд дутуу ирсэн байсан.<br><br>
Тодорхой шалтгааны улмаас хэмнэгдсэн зардлаас дутагдалтай байгаа зардалд шилжүүлэн зохицуулалт хийх боломж Сангийн сайдын баталсан журмаар зохицуулагдсан байгаа бөгөөд энэ журмын дагуу дутагдалтай байгаа төсвийг гүйцээж төлөвлөх боломж байгаа болно.<br><br>
3 ДУГААР БҮЛЭГ.<br><br>
3.2.8. 2018 оны төсөвт зохицуулалт хийсэн байдал, дүнгийн талаар
</td>
<td>
Санал -9-т:<br>
Сангийн яамнаас ирүүлсэн 2018 оны төсвийн төсөл боловсруулах удирдамж, Засгийн газраас баримталж байгаа төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх тогтоол шийдвэрүүдийг зөрчиж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
</td>
</tr>
</table>

<table>
<tr>
<td>
Тайлбар: ОН-ын байгууллагуудаас АЗДТГ нь цахилгааны шит, бусад холбогдох хэрэгслүүдийг сольж шинэчилсэн, гэрэлтүүлэгт хэмнэлттэй led гэрэл ашигладаг болсноос гэрэл цахилгааны зардалд, мөн усны тоолуурыг шинэчлэн батлуулсан, ус алдалтыг бүрэн зогсоож чадсанаар цэвэр бохир усны зардал хэмнэлт гарсан тул зохицуулалт хийлгэсэн. Асрамжийн газар нь зарим зардлаас тодорхой хэмжээний хэмнэлт гарган халаалтын зардлаа шинэ тарифаар төлөхөөр тооцон батлуулсан. Байсныг хэлтсийн зүгээс чиглэл өгсөний дагуу хуучин тарифаар төлбөрөө хийх болсон тул хэмнэлт гаргахаар төлөвлөсөн зардлуудыг буцаан нөхөгдүүлэхээр зохицуулалт хийлгэсэн байна.<br><br>
БОАЖГ нь тогтмол зардлаа ганц өөрийн байгууллагаас төлөхөөр төлөвлөсөн боловч орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа сав газрын захиргаад уг байгууллагын байранд байрлаж тогтмол зардлаас хуваалцан төлж байгаа тул хэмнэлт гарсан. Шинэ, тусдаа байранд орсон тул зөрүүт хамгаалалтын ажилтныг гэрээтээр авч ажиллуулж байгаа бөгөөд хэмнэгдсэн тогтмол зардлыг цалингийн зардалд шилжүүлэн зарцуулж байна.<br><br>
ТЭЦ-ийн байгууллагуудын тогтмол зардлын тухайд цаг агаар дулаарсан үед халаалт авах хоногоо цөөрүүлснээр зохих хэмжээний хэмнэлт гарсны зарлагыг тухайн байгууллагын 2018 оны ХБГ-р тооцоолол хийсний дагуу зохицуулалтыг хийсэн болно. ЗГ-аас болон холбогдох яамдаас өгч байгаа Холбогдох хууль журам, тогтоол шийдвэрийн дагуу төсвийн зарлагын хэмнэлттэй бий болгох зүгээлцэхгүй байгаа шаардлагатай зардлуудад шилжүүлэн зарцуулах эрхийг төсвийн захирагч нарт өгсөн байгаа тул өгөгдсөн эрхийн дагуу дээрх зохицуулалтуудыг хийсэн болно.<br><br>
3.2.9. Зарим төсөвт байгууллага халаалтын гэрээгээ хэмжигдсэн тарифаар тооцож өр төлбөр үүсгэсэн талаар.<br><br>
Тайлбар: Батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаагаа явуулах, өр авлага үүсгэхгүй ажиллах талаарх бичгүүдийг удаа дараа хүргэж, чиглэл өгч ажилласан. Үүнд "2018 оны батлахад анхаарах асуудал, төсвийн онцлог, хэрэгжүүлэх чиглэл"-ийн талаар аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 1/2768 тоот, 10 хуудас хавсралт бүхий албан бичиг, "Зөвлөмж хүргүүлэх тухай" 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 1/327 тоот албан бичиг зэрэг багтаж байгаа бөгөөд хүргүүлсэн зөвлөмж чиглэл, анхаарах асуудлыг сумын удирдлага болон төсвийн захирагч нар хэрэгжүүлэн ажиллаагүй байна. /хүргүүлсэн бичгүүдийг хавсаргав/<br><br>
Мөн түлш халаалтын зардлын дутуут шийдвэрлүүлэх тал дээр онцгой анхаарч холбогдох яам, агентлаг, эрх бүхий албан тушаалтнуудад маш олон бичиг тоот, тооцооллыг хүргэж байгаа бөгөөд одоог хүртэл тодорхой үр дүн гараагүй байгаагийн зэрэгцээ эрчим хүчний зохицуулах хорооноос шинэчилсэн тарифыг мөрдөж ажиллах талаар бичиг тоот ирүүлж байна.<br><br>
3.2.13. Оны эхний хагас жилийн байдлаарх орон тооны хэтрэлтийн талаар.<br><br>
Тайлбар: Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь байгууллагын ажлын албаны даргын 2018 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн Б/04 тоот тушаалаар хэвлэл
</td>
<td>
Санал-10-т:<br>
Цалин, тогтмол зардал, нормативт зардалд илүү төсөв батлуулж, улмаар бусад эд хогшил худалдан авах болон урсгал зардал уруу зохицуулалт хийлгэж байгаа нь төсвийг үндэслэлгүй төлөвлөж байгаагийн илрэл гэж үзэж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
</td>
</tr>
</table>

моддзалап, олон нийтийн ажилтны орон тоог нэмэгдүүлэн баталсан. Санхүүгийн хяналт дотоод аудитын алба нь аймгийн Засаг даргын 2017 оны Б/05 дугаар захирамжаар батлагдсан орон тоогоор ажиллаж байна.

ТЭШ-ийн байгууллагуудын тухайд Мөрөн-2 сургуулийн зүвшд дүү хөгжмийн багш-1, монгол хэл багш-1 цагийн ачааллаас хамааран нэмэгдсэн. Шинэ-Идэр сумын хүүхдийн цэцэрлэг шинээр баригдан ашиглалтад орсноор талбайн хэмжээнээс шалтгаалж нэг үйлчлэгчийн орон тоо нэмэгдсэн. Хатгал, Мөрөн-10 цэцэрлэгт орон тоо нэмэгдээгүй.

**4 ДҮГЭЭР БҮЛЭГ.**

**4.1.3. Сумдын ТТЗ-ийн хэрэгжүүлэх, хөтөлбөр хүрэх үр дүнг үзүүлэлтийг батлах, тайлагнах**

Тайлбар: 2016 оны төсөв батлагдах үед Сангийн яамнаас төсөв батлах тогтоолын загварыг өөрчлөн боловсруулж ирүүлсэн бөгөөд тэр загварт аймгийн хурлын тогтоолын 1 дүгээр хавсралтын улсын төсвөөс авах ТЭШ-ийн санхүүжилтээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний загварыг хассан, сумын хурлын тогтоолын 1 дүгээр хавсралтын "төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн" хавсралтын утга санааг өөрчлөн"төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн үзүүлэлт" нэртэй болгож ирүүлсэн. Энэ утгаар нь аваад үзвэл аймаг, сум зэрэг орон нутгийн байгууллагуудын төсвийг хүрэх үр дүнгээр тодорхойлон баталж, ТЭШ-ийн байгууллагын тухайд ТЕЗ нь бусад яамны түвшинд хүрэх үр дүнг нь тодорхойлохоор байсан.

Өөрчлөгдсөн орсон тогтоолын загварыг ашиглаж 2017, 2018 оны төсвийг баталсан байгаа бөгөөд үүний улмаас ТЭШ-ийн байгууллагуудын төсвийг "хүрэх үр дүн"-гээр тодорхойлж баталдаггүй болно.

Тайлбар бичсэн:

СТСХ-ийн мэргэжилтэн  Г.Базар

***Санал -11-т:***

Сумдын ТТЗ-д төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөрөөр нь тайлагнаж, хяналт хийлгэхгүй байгаа нь аудитаар нотлогдож байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

67123. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Уран дөш баг
Утас: 70382300. факс: 70381001
www.khovsgol.gov.mn

2018. 11. 15 № 1/2502

танай ________ -ны № ________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

“2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц” гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчилд өгсөн албан шаардлага, зөвлөмжийг цаашид бүх шатанд хэрэгжүүлэн ажиллана.

ДАРГА Л.ГАНБОЛД

0113445

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Л.ГАНБОЛД
ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Уранцэнхэр баг
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2018.11.05 № САГ-2018/02/-ЕА-ХАТАГ-21/85

Зөрчил арилгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд аудит хийх төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд “2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2018 оны 2 дугаар сарын 07-ний өдрийн 01 тоот тогтоолоор давсан орлого дансны үлдэгдэлийг зарцуулах тодотгол хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 (...Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ ... ); Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 1.1 (...Засгийн газраас Монгол Улсын 2018 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль санаачлахгүй байх зарчим баримталж байгаатай холбогдуулан батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, аливаа өр, авлага үүсгэхгүй байхаар үйл ажиллагаагаа зохион байгуулах...) заалтыг тус тус зөрчсөн байна.

**Иймд:** Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т (...аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..), Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д (...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө...) гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтад заасан нөхцөл байдал үүссэн үед аймгийн төсөвт тодотгол хийх санал боловсруулж, өргөн мэдүүлж байхыг аймгийн Засаг дарга Л.Ганболд, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Сувд нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН[1]:**
Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Тэгшдэлгэр
Хянасан:
Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер Ж.Отгончимэг

6717144193
PIOA0662 9979665

**ЗӨВШӨӨРСӨН:**
Аймгийн Засаг дарга Л.Ганболд

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Сувд

[1] *Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцах албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

ХОВСГОЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Уран-Өндөр баг
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас,факс: 70-38 37-93
Э-майл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2018.11.05 № САТ-2018/03/-СА-3601/АГ-04/40

БҮРЭНТОГТОХ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.СОНИНПИЛ ТАНАА

Батлагдсан төсвийн хүрээнд ажиллах тухай

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд аудит хийх төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд “2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2009 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 01 тоот тогтоолоор батлагдсан 1430 төгрөгөөр 2018 оны төсөвт халаалтын зардлыг тооцсон байна. Гэтэл Бүрэнтогтох сумын төсөвт байгууллагууд 1 м3 талбайн халаалтын зардлыг 1798 төгрөгөөр тооцон гэрээ байгуулж, батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулснаас, эхний 9 сарын байдлаар 249,000,000 (Хоёр зуун дөчин есөн сая ) төгрөгийн өр үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 7.3-т (...орон нутгийн дулааны үнэ тарифыг нэмэгдүүлэхгүй байх, төвлөрсөн халаалтад холбох, сумдын уурын зуухыг аймгийн төвийн уурын зуухтай нэгтгэн зохион байгуулахдаа төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байх, сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудын түлш халаалтын зардлыг өр, авлага үүсгэхгүйгээр батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлэх..) гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т (... аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх ...), Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д (... дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө ...) гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Цаашид батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, 2018 онд өр, авлага үүсэхгүйгээр төлөвлөн ажиллахыг шаардаж байна.

2. Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бүрэнтогтох сумын Засаг дарга Г.Сонинпилд даалгав.

**“АЛБАН ШААРДЛАГЫГ**

ӨГСӨН[1]:
Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Тэгшдалгэр
Хянасан:
Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер Ж.Отгонжаргал

ЗӨВШӨӨРСӨН:
Бүрэнтогтох сумын Засаг дарга Г.Сонинпил

[1] Акт, албан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас гаргасан албан шаардлага, төлбөрийн актыг [illegible] биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг [illegible] хариуцлага хүлээлгэх тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх” гэж заасны дагуу хариуцлага хүлээлгэх [illegible] эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

1551413

ГАЛТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
М.ДОЛЖИНЖАВ ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Уран дөш баг
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас,факс: 70-38-37-93
Э-майл: khuvsgol@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2018.11.05 № [illegible] 08/43

Батлагдсан төсвийн хүрээнд ажиллах тухай

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны "Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай" 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд аудит хийх төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд "2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2009 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 01 тоот тогтоолоор батлагдсан 1430 төгрөгөөр 2018 оны төсөвт халаалтын зардлыг тооцсон байна. Гэтэл Галт сумын төсөвт байгууллагууд 1 м3 талбайн халаалтын зардлыг 1716 төгрөгөөр тооцон гэрээ байгуулж, батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулснаас эхний 9 сарын байдлаар 27,600,000 (Хорин долоон сая зургаан зуун мянган) төгрөгийн өр үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 7.3-т (...орон нутгийн дулааны үнэ тарифийг нэмэгдүүлэхгүй байх, төвлөрсөн халаалтад холбох, сумдын уурын зуухыг аймгийн төвийн уурын зуухтай нэгтгэн зохион байгуулахдаа төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байх, сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудын түлш халаалтын зардлыг өр, авлага үүсгэхгүйгээр батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлэх...) гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т (... аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх ...) Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д (... дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө ...) гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Цаашид батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, 2018 онд өр, авлага үүсгэхгүйгээр төлөвлөн ажиллахыг шаардаж байна.

2. Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Галт сумын Засаг дарга М.Должинжавд даалгав.

**"АЛБАН ШААРДЛАГЫГ"**

ӨГСӨН[1]
Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын
ахлах аудитор Тэгшдэлгэр
Хянасан:
Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын
хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер
Ж.Отгончимэг

ЗӨВШӨӨРСӨН
Галт сумын Засаг дарга
М.Должинжав

[1] Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн [illegible]

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Уранган баг
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас,факс: 70-38 37-93
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2018.11.05 № [illegible]-06/46

ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Т.ЭРДЭНЭБАТ ТАНАА

Батлагдсан төсвийн хүрээнд ажиллах тухай

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны "Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай" 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд аудит хийх төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд "2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2009 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 01 тоот тогтоолоор батлагдсан 1430 төгрөгөөр 2018 оны төсөвт халаалтын зардлыг тооцсон байна. Гэтэл Төмөрбулаг сумын төсөвт байгууллагууд 1 м3 талбайн халаалтын зардлыг 1738 төгрөгөөр тооцон гэрээ байгуулж, батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулснаас эхний 9 сарын байдлаар 137,700,000 (Нэг зуун гучин долоон сая долоон зуун мянган) төгрөгийн өр үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 7.3-т (...орон нутгийн дулааны үнэ тарифийг нэмэгдүүлэхгүй байх, төвлөрсөн халаалтад холбох, сумдын уурын зуухыг аймгийн төвийн уурын зуухтай нэгтгэн зохион байгуулахдаа төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байх, сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудын түлш халаалтын зардлыг өр, авлага үүсгэхгүйгээр батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлэх...) гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т (... аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх ...), Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д (... дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө ...) гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Цаашид батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, 2018 онд өр, авлага үүсэхгүйгээр төлөвлөн ажиллахыг шаардаж байна.

2. Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Төмөрбулаг сумын Засаг дарга Т.Эрдэнэбатад даалгав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН[1]:**
Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Тэгшдэлгэр
Хянасан:
Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер Ж.Оттончимэг

**ЗӨВШӨӨРСӨН:**
Төмөрбулаг сумын Засаг дарга Т.Эрдэнэбат

[1] [illegible]

[illegible]

ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
И.НАЙМАНЖИН ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандэш баг
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас,факс: 70-38 37-93
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2018.11.05 № БАТ- 2018/02/-СА-Хө/ТМАГ- 04/44

Батлагдсан төсвийн хүрээнд ажиллах тухай

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд аудит хийх төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд “2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илрэв. Үүнд:

Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2009 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 01 тоот тогтоолоор батлагдсан 1430 төгрөгөөр 2018 оны төсөвт халаалтын зардлыг тооцсон байна. Гэтэл Жаргалант сумын төсөвт байгууллагууд 1 м3 талбайн халаалтын зардлыг 1738 төгрөгөөр тооцон гэрээ байгуулж, батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулснаас эхний 9 сарын байдлаар 9.700.000 (Есөн сая долоон зуун мянган) төгрөгийн өр үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2.заалт, Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 7.3-т (...орон нутгийн дулааны үнэ тарифийг нэмэгдүүлэхгүй байх, төвлөрсөн халаалтад холбох, сумдын цэврын зуухыг аймгийн төвийн уурын зуухтай нэгтгэн зохион байгуулахдаа төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байх, сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудын түлш халаалтын зардлыг өр, авлага үүсгэхгүйгээр батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлэх...) гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т (... аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх ...), Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д (... дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө ...) гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Цаашид батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, 2018 онд өр, авлага үүсгэхгүйгээр төлөвлөн ажиллахыг шаардаж байна.

2. Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Жаргалант сумын Засаг дарга И.Найманжинд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН[1]:**
Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын
ахлах аудитор Л.Тэгшдэлгэр
Хянасан:
Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын
хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер
Ж.Отгончимэг

**ЗӨВШӨӨРСӨН:**
Жаргалант сумын Засаг дарга
И.Найманжин

[1] Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас гаргасан албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харьяалах албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

1551417